

ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 3 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит хуралдаан 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр хуралдаж дараах асуудлыг хэлэлцэн батлав.

1. 2019 онд ойгоос бэлтгэх модны тоо хэмжээний дээд хязгаар батлах тухай,
2. "Дорнод аймгийн есөн гайхамшиг"-ийг батлах тухай,
3. Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний дагуу газрын тос, уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс аймгийн Орон нутгийн хөгжлийн санд мөнгөн дэмжлэг төвлөрүүлэх, хуваарилах, зарцуулах тухай,
4. Аймгийн 2019 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай,
5. Төрийн байгууллагуудад газар шилжүүлэх тухай,
6. Бодлогын хорооны даргыг сонгох тухай,
7. Тогтоол батлах тухай,

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2019 оны 03 дугаар сард 2 удаа хуралдаж, Зарим хүмүүсийг төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулах тухай, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 10 дугаар хуралдаан товлон зарлан тухай, Дорнод аймгийн зарим сумдад гарсан адууны өвчний талаарх цаг үеийн мэдээлэл, зохион байгуулсан арга хэмжээний талаарх асуудлуудыг тус тус хэлэлцэн батлав.

Төлчин эмэгтэйчүүдээ алдаршуулах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцох зорилгоор Цагаан-Овоо сумын ЗДТГ-аас "Төлчин эмэгтэйчүүдийн чуулга, уулзалт"-ыг зохион байгуулав.

Энэ жилийн чуулга уулзалтанд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Л.Хишигтогтох, Сэргэлэн сумын 1 дүгээр багийн төлчин эмэгтэйчүүдийн төлөөлөл болон Цагаан-Овоо сумын 6 багийн 200 гаруй төлчин эмэгтэйчүүд оролцсон бөгөөд 2018 оны "МЭНД ТӨЛЧИН"-ийг шалгаруулж шагнаж урамшууллаа. Энэхүү арга хэмжээний үеэр аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэргэжилтнүүд болон сумын Мал эмнэлэг үржлийн тасгийн мэргэжилтнүүд оролцож, мал аж ахуйн бодлого, малын эрүүл мэнд, нийгмийн даатгалын талаар сургалт хийсэн ба Happy life ТББ-ын тэргүүн Э.Эрдэнэ-Очир, Хүний хөгжлийн лектор Н.Гантулга нар хайр ба гэр бүлийн үнэ цэнэ сэдвээр лекц уншлаа.

Зэвсэгт хүчний 98 жилийн ойг тохиолдуулан аймгийн ИТХ-ын дарга Л.Хишигтогтох, аймгийн Засаг даргын орлогч Ш.Ёл, Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын Захирагч П.Мөнхтөр, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч Б.Тэгшжаргал болон бусад албаны хүмүүс эх орныхоо төлөө амиа өгсөн эрэлхэг дайчдын хөшөөнд хүндэтгэл үзүүлж, Монгол дайчдын хөшөөнд цэцэг өргөлөө.

"Мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлого"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улс, орон нутгийн салбарын бодлогыг танилцуулах, мал аж ахуйн салбарт тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх, малын ашиг шимийг нэмэгдүүлэх, бэлчээрийг зохистой ашиглах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зорилгоор аймгийн "МАЛЧДЫН ЗӨВЛӨГӨӨН-2019"-ийг зохион байгуулав. Зөвлөгөөнд аймгийн ИТХ-ын дарга Л.Хишигтогтох, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, ХХААХҮ-ийн дэд сайд Ж.Сауле болон сумын Засаг дарга, малчдын 400 гаруй төлөөлөл оролцов.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Л.Хишигтогтох Дорнод аймагт томилолтоор ажиллаж буй Монгол Улсын Засгийн газрын захиалгаар Мэргэжлийн Боловсролын салбарын суурь судалгааг хийж байгаа Юнескогийн багийн гишүүн хадагтай Керолин Даяа, Европын холбооны Монголын техник, мэргэжлийн боловсрол сургалтын салбарыг дэмжих төслийн хүрээнд хийгдэж буй Чанарын баталгаажуулалтын төслийн багийн гишүүн Р.Бат-Эрдэнэ, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн арга зүйч Л.Цэцгээ нарыг хүлээн авч уулзан, мэргэжлийн боловсролын салбарын цаашдын хөгжлийн асуудлаар санал бодлоо солилцлоо.

Хяналт, шинжилгээ үнэлгээний чиглэлээр:

Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг орон нутгийн бодлого, шийдвэр, "Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор төр, нутгийн захиргааны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжээс дэвшүүлсэн 2019 оны зорилтот жилийн нэршлийг аймгийн Засаг даргын 2019 оны А/100 дугаар захирамжаар батлуулан агентлаг, сумдад хүргүүлэн ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх аймгийн Засаг даргын Тамгын газрын 2018 оны үйл ажиллагааны тайланг 86.3 хувийн биелэлттэй хүргүүллээ. Үүнээс: Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ 83.3 хувийн биелэлттэй, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ 85.0 хувийн биелэлттэй, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ 85.0 хувийн биелэлттэй тус тус үнэлэгдсэн. Мерит төслийн "Жендэр-Хяналт-шинжилгээ, үнэлгээ"-ний чиглэлийн Төв аймагт зохион байгуулагдсан сургалтад тус хэлтсийн дарга хамрагдав.

ХОЁР.ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Орон нутгийн нийт орлого 4986.9 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 5478.4 сая төгрөг, үүнээс татварын орлого 1323.8 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 1634.1 сая төгрөгт хүрч 310.3 сая төгрөгөөр, татварын бус орлого 3663.1 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 3844.3 сая төгрөгт хүрч 181.2 сая төгрөгөөр тус тус даван биеллээ.

Орон нутгийн төсвийн нийт орлого

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөндүнгээр/	Өөрчлөлт	
			Тоо	Хувь
002 ОРОН НУТГИЙН ОРЛОГО	16,118,894,900.00	15,641,078,608.79	(477,816,291.21)	97.04
003 ТАТВАРЫН ОРЛОГО	4,307,974,100.00	4,249,645,248.16	(477,816,291.21)	97.04
004 Орлогын албан татвар	2,669,431,000.00	2,852,420,833.42	(58,328,851.84)	98.65
016 Хөрөнгийн албан татвар	355,818,200.00	303,212,855.21	(52,605,344.79)	85.22
021 Бусад татвар, төлбөр, хураамж	1,449,771,500.00	1,220,128,416.10	(229,643,083.90)	84.16
041 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,810,920,800.00	11,391,433,360.63	(419,487,439.37)	96.45
042 Нийтлэг татварын бус орлого	440,120,000.00	715,524,660.63	275,404,660.63	162.57
049 Хөрөнгийн орлого	-	-	-	#DIV/0!
056 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	9,061,166,000.00	8,849,630,000.00	(211,536,000.00)	97.67
057 Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	-	-	-	#DIV/0!
058 Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	8,243,376,000.00	8,206,360,000.00	(37,016,000.00)	99.55
059 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	817,790,000.00	643,270,000.00	(174,520,000.00)	78.66

Төсвийн зарлагын талаар:

Аймгийн төсвийн нийт зарлага 16989.7 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 12883.1 сая төгрөгийн гарсан гүйцэтгэлийг бүрэн санхүүжүүлсэн.

Нийт төсвийн зарлагын

Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамжинд 58 %

Тогтмол зардалд 5 %

Бараа үйлчилгээний бусад зардалд 36 %

Хөрөнгийн зардалд 1 % байна.

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 649.3 сая төгрөг, Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 6559.1 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 8206.4 сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүллээ.

Орон нутгийн төсвийн нийт зарлага

/ төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,989,711,400.00	12,883,106,068.38	(4,106,605,331.62)	75.8
Цалин хөлсболон нэмэгдэл урамшил	7,746,297,000.00	7,357,399,832.39	(388,897,167.61)	95.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	968,173,300.00	929,506,419.88	(38,666,880.12)	96.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,533,796,600.00	1,083,650,073.00	(450,146,527.00)	70.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	881,729,500.00	676,109,957.81	(205,619,542.19)	76.7
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,075,299,100.00	279,779,805.20	(1,795,519,294.80)	13.5

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтэд тогтмол хяналт тавьж, 2019 онд аймгийн Засаг даргын 132 захирамж, 10 сумын Засаг даргын 525 захирамж, сумын Засаг даргын Тамгын газрын даргын 113 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянан гарсан зөрчил, дутагдалд 12 удаагийн зөвлөмж хүргүүлээд байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж нийт 23 өргөдөл ирүүлснээс 19 өргөдөл гомдлыг шийдвэрлэн холбогдох хариуг иргэдэд өгч 4 өргөдөл шийдвэрийн шатандаа байна. Аймгийн Засаг даргад хандан мөнгөн тусламж хүссэн 9 иргэнд 4,300,000 /дөрвөн сая гурван зуун мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн сангийн хөрөнгөөс олгуулах ажлыг зохион байгууллаа. Монгол улсын Засгийн газраас 2019 оныг "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил", Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас "Хариуцлагатай хэрэглээ - Хэрэглэгчийн эрхийн жил" болгон зарласантай холбогдуулан Засгийн газрын 2016 оны 233 дугаар тогтоолоор баталсан "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Дорнод аймагт Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Олон улсын өдрөөр дараах ажил, арга хэмжээг зохион байгуулав.

Төрийн байгууллагын үйл ажиллагаа, ил тод байдлыг хангах, төрийн албан хаагчдын ёс зүй, хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд нь хяналт тавих, иргэдийн санал хүсэлтийг шуурхай хүлээн авч, шийдвэрлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын Иргэд хүлээн авах төвд "Нээлттэй утас-

70582233" дугаарыг 6 дахь жилдээ ажиллуулж байна. Тус утсанд ирүүлсэн дуудлага, мэдээлэлд дүн шинжилгээ хийн иргэдээс хамгийн их санал, хүсэлт ирүүлж хандсан аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Улсын бүртгэлийн хэлтэс, "Дорнод НАА" ОНӨААТҮГ-ын ажилтан, албан хаагчид болон үйл ажиллагаатай 2019 оны 03 дугаар сарын 14-19-ний өдрүүдэд танилцаж, аймгийн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус салбар зөвлөл Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль болон Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар зөвлөгөө, чиглэл өгч ажиллалаа.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Аймгийн Засаг даргын орлогч, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлийн дарга Ч.Ганбатаар ахлуулсан ажлын хэсэг 3 дугаар сарын 14-ний өдөр аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газарт Ерөнхий боловсролын 11 сургууль, Сургуулийн өмнөх боловсролын 19 байгууллагын удирдлагуудтай уулзалт хийлээ.

Уулзалтаар жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдөр орон даяар тэмдэглэдэг "Олон улсын хэрэглэгчийн өдөр"-ийн хүрээнд "Хүүхэд хэрэглэгч" аяныг "Аюулгүй, ухаалаг бараа, бүтээгдэхүүн" сэдвийн дор зохион байгуулж байгаа үйл ажиллагаагаа танилцуулж, ажлын хэсгийн ахлагчийн зүгээс холбогдох мэдээлэл, үүрэг чиглэл өглөө.

Хүүхэд-Хэрэглэгч аяны хүрээнд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлийн даргын баталсан хөтөлбөрийн дагуу Хэрлэн сумын 10 сургуулийн 1800 гаруй сурагчдад Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Боловсрол, соёл урлагийн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Цагдаагийн газар, Татварын хэлтэс, Эрчим хүчний зохицуулах зөвлөл, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн Дорнод салбар, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон худалдаа, үйлчилгээний төвүүд болох хувийн хэвшлийн "Дээшлэх нар" ХХК, "Хэрлэн номин" ХХК, "Дорнод Хүнс" ХХК, "Ольхон арал" ХХК-тай хамтран "Эрүүл, аюулгүй хүнс", "Цахим орчин дахь зөв хэрэглээ", "Усны зохист хэрэглээ", "Эрчим хүч хэрэглээ-хэмнэлт" "Хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалт зэрэг сэдвүүдээр сургалт нөлөөллийн ажил зохион байгууллаа.

Дорнод аймаг 2019 оныг Аялал жуулчлалыг дэмжих жил болгон зарласан. Үүнтэй холбогдуулан өвлийн аялал жуулчлалын хаалт, зуны аялал жуулчлалын нээлтийн үйл ажиллагаа, олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг угтан "Хэрэглэгчээ сонсьё" өдөрлөгийг 2019.03.14-ний өдөр аймгийн Хөгжимт драмын театрт зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 6 төрийн байгууллага, 12 аж ахуйн нэгж байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд оролцож хэрэглэгчдэд ажил, үйлчилгээгээ танилцууллаа.

Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус салбар зөвлөл Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Буйр нуур-Мэнэнгийн талын сав газартай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчдад "Цэнгэг ус-тэгш хүртээмж" уриан дор хот дотор танилцуулга аялал зохион байгуулж сурагчдад усны анхны үнэ, өртөг, хэрэглэгчдэд хэрхэн хүрч буй талаар мэдээлэл өглөө. Мөн аймгийн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлөөс 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Хөнгөн хүнсний үйлдвэрийн ажилчдын өдрийг угтан "Эрүүл хүнс-1" хэлэлцүүлгийг зохион байгуулж хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал цаашид хэрхэн шийдвэрлэх талаар санал солилцлоо. Тус хэлэлцүүлгийн арга хэмжээнд 11 төрийн байгууллага, 2 төрийн бус байгууллага, 57 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон байна.

Тус хэлэлцүүлгийн үр дүнд үйлдвэрлэгч, хэрэглэгчийн өмнө тулгамдсан олон асуудлуудыг орон нутгийн бодлого, үйл ажиллагаанд тусган, хамтран ажиллахаар шийдвэрлэлээ. Дорнод аймгийн төрийн албан хаагчдын "Хандлага-өөрчлөлт" нэгдсэн зөвлөгөөний төрийн тусгай албан хаагчдын салбар зөвлөгөөнийг батлагдсан төлөвлөгөөний дагуу 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 14:00-18:35 цагийн хооронд аймгийн Цагдаагийн газрын хурлын танхимд зохион байгууллаа. Тус салбар зөвлөгөөний хуралдаанд аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээ үзүүлж байгаа хууль сахиулах тусгайлсан чиг үүрэг бүхий 12 байгууллагын 95 ажилтан, албан хаагч оролцлоо.

Тус салбар зөвлөгөөнөөр:

- Зүүн бүсийн төв Онцгой байдлын газрын тэргүүн туршлага, танилцуулга
- аймгийн Цагдаагийн газрын тэргүүн туршлага, танилцуулга,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тэргүүн туршлага, танилцуулга,
- Хилийн 0132 дугаар ангийн тэргүүн туршлага танилцуулга,
- Зэвсэгт хүчний 0327 дугаар ангийн тэргүүн туршлага, танилцуулга,
- Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 085 дугаар тусгай ротын тэргүүн туршлага, шинэ санал, санаачилга, хамтын ажиллагааны талаар зөвлөгөөнд оролцогчдод танилцууллаа.

Архивын чиглэлээр:

Аймгийн Архивын тасаг нь Монгол улсын Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх" үндэсний хөтөлбөрийн дөрөвдүгээр үе шат /2017-2020/-нд гүйцэтгэх арга хэмжээний төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2018 оны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор 2018 оныг "Иргэн таны төлөө" зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

1. Албан хэрэг хөтлөлт, хууль тогтоомж, шийдвэрийн талаар:

Архивын тасагт 2018 оны 03 дугаар сарын 01-ний байдлаар ирсэн 39 албан бичгийг хүлээн авч бүртгэн, гадагш 57 албан бичиг боловсруулж явуулсан байна. 11 хариутай бичгийг хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Архивын тасгаас 2018 онд хийх ажлын төлөвлөгөө, нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөө, цахимжуулах баримтын төлөвлөгөө, хяналт шалгалтын төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна.

2. Баримт ашиглалтын талаар:

2018 оны 03 дугаар сард 2 байгууллага /Аймгийн ИТХ, аймгийн ЗДТГ/ 101 иргэнээс лавлагаа мэдээллийн захиалга хүлээн авч 332 хуулбар, 3 иргэний 19 оны малын А данс, 19 тодорхойлолт гаргаж нийтдээ 1,339,0 төгрөгийн орлого оруулав. Хадгаламжийн сангаас 97 хөмрөгийн 368 хадгаламжийн нэгжийг гаргаж ашиглан бүртгэж буцаан байрлуулав. 2018 оны 03 дугаар сард нийт давхардсан тоогоор 45 байгууллагын 15 төрлийн 12487 хэвлэмэл хуудасны захиалга авч стандартын хэвлэж дугаарлан бүртгэл хөтөлж, нийтдээ 45 байгууллагын 801670 төгрөгийн төлбөр орохоос 28 байгууллагын 527050 төгрөгийн орлого орсон. 1,2 сарын үлдэгдэл төлбөр болох 59000 төгрөг орсон. Бүгд 586050 төгрөгийн орлого орсон байна. Шинээр 3 байгууллагын материалыг хүлээн авч, эх хувийг бэлтгэн стандартын дагуу хэвлэв.

3. Нөхөн бүрдүүлэлт:

"Аглут" компанийн гүйцэтгэсэн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн барилгын цаасан суурьтай, цахим тээгч бүхий 14 хадгаламжийн нэгжээр сан хөмрөгөө нөхөн бүрдүүллээ.

4. Цахим хэлбэрт оруулсан баримтын талаар:

2018 онд цахимжуулах төлөвлөгөөг боловсруулж, сар, улирал, өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөн ажиллаж байна.

2018 оны 03 сарын байдлаар Дорнод аймгийн Төрийн архивын 5 дансны 5 хөмрөгийн 159 хадгаламжийн нэгжийн 19784 хуудас баримтыг шивж байршуулав.

ØЦахим холболт- 159 хадгаламжийн нэгжийн 19784 хуудас баримт

ØХүний нэр-69249

ØБайгууллагын нэр-219

ØГазар зүйн нэр-1952

ØЗаалт 19712

5. Нягтлан шалгалтын талаар:

1 хөмрөгийн 1 дансны /Дулааны цахилгаан станц-13/-ын 176 хадгаламжийн нэгжийн 24747 хуудас баримтыг нягтлан шалгаж, 183 хадгаламжийн нэгжийн 14278 хуудас баримтыг дугаарлан, 228 хадгаламжийн нэгжийн 18051 хуудас баримтыг үдэж хавтаслан, нүүр бичилтын ажлыг хийсэн байна.

1 хөмрөгийн 1 дансны дансны /Дулааны цахилгаан станц-13/-ын 78 хадгаламжийн нэгжийн 10787 хуудас баримтыг скайнердсан.

Хөмрөг 92 буюу Нэгдсэн эмнэлгийн 1976-1980 оны 10 хадгаламийн нэгжийн 2136 хуудас баримтанд нягтлан шалгалт дахин боловсруулалтын ажлыг хийж, нэгж тасаг бүрээр салгаж 18 хадгаламжийн нэгж болголоо. Мөн гэмтэлтэй болон сэргээн засварлах шаардлагатай 568 хуудсыг сэлбэн засч, нуруу шил наалаа.

Хөмрөг 92 буюу Нэгдсэн эмнэлгийн 1965-1969 оны 23 хадгаламжийн нэгжийн 899 хуудас баримтыг фотошопдож Төрийн архивын програмд оруулахад бэлэн болгов.

6. Бусад ажлын талаар:

Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр 2018 онд шалгалт хийх 23 байгууллагад албан бичиг, төлөвлөгөөг хүргүүлэв. Мөн 10 байгууллагын 22 ажилтны Архивын ерөнхий газрын сургалтад оролцуулах албан бичгийг тус тусын холбогдох байгууллагуудад хүргүүлж ажилласан. Архивын ерөнхий газраас Архивч-операторчдийн хөдөлмөрийн гэрээний загварын дагуу гэрээг байгуулан

Архивын ерөнхий газарт 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 48 дугаар албан бичгээр албан бичгээр хүргүүлэв. Аймгийн Нисэх буудал, Матад сумын Соёлын төв, Дорнод их сургууль, Цагаан-овоо сум ЗДТГ, Булган сумын ЕБС, Баянтүмэн сумын цэцэрлэг, Баянтүмэн сумын эрүүл мэндийн төв зэрэг байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийг хариуцсан ажилтнуудад хадгаламжийн нэгж үүсгэх, архивын баримтыг байнга, түр хадгалах хадгаламжийн нэгж хэрхэн үүсгэх талаар заавар зөвлөгөөг өгч ажиллав. Эрүүл мэндийн газар, Аймгийн Прокурорын газарт архив, албан хэрэг хөтлөлт стандартын чиглэлээр сургалтыг зохион байгуулж 65 ажилтан, албан хаагчдад оролцсон байна. Чулуунхороот сумын Соёлын төв, Ерөнхий боловсролын сургууль, Матадын Эрүүл мэндийн төв, Сэргэлэн сумын ЗДТГазар зэрэг байгууллагуудад хадгаламжийн нэгж хэрхэн үүсгэх талаар заавар зөвлөгөө өгч ажилласан байна. Хадгаламжийн сангийн цэвэрлэгээ үйлчилгээг 3 сарын 09, 31-ний өдрүүдэд, чийг дулааны хэмжилтийн бүртгэлийг 3 сарын 9, 16, 23-ны өдрүүдэд хөтөлж ажилласан байна.

ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Боловсролын чиглэлээр:

Зүүн Монголын уламжлалыг сэргээн тодруулах, хөгжүүлэн шинэ шатанд гаргах, бүс нутгийн ард түмний язгуур уламжлалт урлаг, соёл, ёс заншлыг сэргээх, өсвөр залуу үеийг үндэстэн ястнаараа бахархах, эх оронч үзлийг буй болгох зорилго "Үл бүдгэрэх их өв" төслийн сургалтад Дорнод аймгийн Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, суралцагчид, сумдын ардын авьяастан сонирхогчид, ахмадын төлөөлөл нийт 168 хүн хамрагдлаа.

"Элсэлтийн ерөнхий шалгалт 2019"-ийн хүрээнд Монгол хэл, бичгийн шалгалтыг 3 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулав. Шалгалтад нийт 13 сургуулийн 243 суралцагч хамрагдав.

Улсын Олимпиадын II даваа 3 дугаар сарын 25-наас Биологийн хичээлээр эхэлсэн бөгөөд 4 дүгээр сарын 10-нд бүх судлагдахуун хичээлүүдийн олимпиад дуусч нэгдсэн дүнгээ гаргалаа.

Монголын Зохиолчдын эвлэлийн Дорнод аймаг дахь салбар, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газар, аймгийн Төв номын сан хамтран "Дэлхийн яруу найргийн өдөр"-ийг угтаж хоёр дахь жилдээ 3 дугаар сарын 21-нд "Талын найраг" уншлагын өдрийг зохион байгуулав. Уншлагад өсвөрийн яруу найрагч, утга зохиолын нэгдлийн гишүүн нийт 50 гаруй яруу найрагчид шүлэг найргаа уншиж сонордуулсан байна.

Халх голын дайны ялалтын 80 жилий ойг угтаж "Тэд бидний төлөө, Бид тэдний төлөө" аяны хүрээнд Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн хүүхдүүдэд уулзалт ярилцлага, Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 98 жилийн ойн өдрөөр Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн үйл ажиллагаатай танилцах аялал зэргийг зохион байгуулав. Арга хэмжээнд бэлтгэл бүлгийн 2 ангийн нийт 60 хүүхэд хамрагдав.

Монгол цэргийн өдөр-Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 98 жилийн ойн хүрээнд Халхын голын 1939 оны байлдааны түүхэн ялалтыг хүүхэд, залуучуудад сурталчлан таниулах, ирээдүй хойч үедээ эх оронч үзэл, хүмүүжлийг олгох зорилгоор зохион байгуулагдсан "Хайрлан дуулах Эх орон" тэмцээнд 15 сургуулийн 600 гаруй сурагч багийн мэндчилгээ, гоцлол дуу, найрал болон цөөхүүл дуу, хамтлаг бүжиг гэсэн төрлүүдээр таван бүсэд хуваагдан өрсөлдөж:

1 дүгээр байр Хэрлэн сумын 8 дугаар сургууль,

2 дугаар байр Хэрлэн сумын Хан-Уул цогцолбор сургууль,

3 дугаар байр Дорнод ахлах сургууль,

Тусгай байр Хэрлэн сумын 1 дүгээр сургууль, Хэрлэн сумын 12 дугаар сургууль тус тус шалгарсан байна.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд аймгийн Засаг даргын орлогч, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлийн дарга Ч.Ганбатаар ахлуулсан ажлын хэсэг 3 дугаар сарын 14-ний өдөр аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газарт Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын удирдлагуудтай "Хүүхэд хэрэглэгч" сэдвийн хүрээнд уулзалт зохион байгуулав.

Уулзалтын үеэр жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдөр тохиодог "Олон улсын хэрэглэгчийн өдөр"-ийн хүрээнд оролцогч байгууллагуудын төлөөлөл "Хүүхэд хэрэглэгч" сэдвийн хүрээнд зохион байгуулж буй үйл ажиллагаагаа танилцуулж, ажлын хэсгийн ахлагчийн зүгээс холбогдох мэдээлэл, үүрэг чиглэлүүдийг өгөв.

Халхын голын дайны ялалтын 80 жилийн ойн хүрээнд Хэрлэн сумын Улсын тэргүүний 12 дугаар цэцэрлэгийн бүтээлч багш ажилчид, эцэг эхчүүдийнхээ хамтаар "Хүүхэд өсвөр үеийнхэнд цэрэг эх

оронч хүмүүжил олгох жил"-ийн хүрээнд "Баатар хот", "Халх гол 80" мини музей, макет, зурагт самбар, үзмэр, хүндэтгэлийн болон бахархлын булан байгуулан хүүхдүүдэд мэдлэг, мэдээлэл өгч ажиллаж байна.

"Монголын улаан загалмай нийгэмлэг" үндэсний хүмүүнлэгийн байгууллага, Дорнод аймгийн Улаан загалмайн хороо хамтран анхан шатны Улаан загалмайн хороодын "Төр-улаан загалмайн түншлэл" анхдугаар зөвлөгөөн, урлагийн бага наадмыг Чойбалсан хотноо 3 дугаар сарын 3-4-ний өдрүүдэд зохион байгуулав. Уг үйл ажиллагааны үеэр явагдсан сумдын Улаан загалмайн анхан шатны салбар хороодын урлагийн наадамд нийт 7 багийн 70 гаруй уран бүтээлчид оролцож, "Тэргүүн байр"-ыг Баян-Уул сумын баг эзэлсэн байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр

Хүүхдийн хөгжил, оролцооны талаар:

Хүүхэд багачуудын авьяас чадварыг нээн хөгжүүлэх, ардын дуу, хөгжмийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, ардын дууны өв сангаас суралцуулах, хүүхдийн дууны урын санг баяжуулах, мартагдсан дууг сэргээн өвлүүлэх зорилгоор ардын болон хүүхдийн дуу дуулаачдын "Дуулах өв 2019" аймгийн наадмыг 3 насны ангиллалаар зохион байгуулав. Уг наадамд ерөнхий боловсролын 19 сургуулийн 47 сурагч оролцсон бөгөөд "Дуулах өв 2019" улсын уралдаанд 6-9 насны ангилалд Д.Мишээл, "Уран сэтгэлгээт дуучин", 14-17 насанд Б.Ариунбат "Уран мэдрэмжит дуучин"-аар тус тус шалгарав.

Хүүхдийн хөгжлийн цирк, бүжиг, шатрын дугуйлан, сургалтад нийт 31 хүүхэд суралцаж байгаа бөгөөд энэ сард дугуйлангийн үйл ажиллагаатай ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаарын Чита хотын 2 дугаар сургуулийн багш, ажилчид танилцан, цаашид хамтран ажиллах ажлын чиглэлийг хэлэлцэв.

Хүүхдийн хамгааллын талаар:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга нарын хамтарсан 2017 оны А/179, А/0138 дугаар тушаал "Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх журам"-ын дагуу баталсан сургалтын хөтөлбөрөөр насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдэж шүүхээс арга хэмжээ авагдсан хүүхдүүдэд "Хүчирхийлэл, түүний тухай үндсэн ойлголт" сэдэвт сургалтыг зохион байгуулж, амьдрах ухааны сургалтанд хамруулан төлөвшил олгож байна.

Мөн "Зан үйлд нөлөөлөх" сургалтыг сар бүр тогтмол явуулж байгаа бөгөөд энэ сард нийт 4 удаагийн сургалтад нийт 34 хамруулж, эерэг зан үйлийг төлөвшүүлж, зөвлөгөө мэдээлэл өгөв.

Хүүхдийг ивээх сангийн Дорнод аймаг дахь салбартай хамтран хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдэд арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд Хэрлэн сумын 1, 4 дүгээр багийн хамтарсан багийн гишүүдийг хамруулан кейс хэлэлцүүлэг зохион байгуулж, кейст үйлчилгээ үзүүлэхэд тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийж, арга зүйн зөвлөгөө өгөв.

Гэр бүлийн хөгжил, хамгааллын талаар:

Засгийн хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас "Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр "Хүүхэд хамгаалалд эцэг, эхийн оролцоо" сэдэвт уулзалтыг зохион байгуулав. Уулзалтын хүрээнд орон нутгийн байгууллага, аж ахуй, нэгжийн дэргэдэх эцэг, эхийн зөвлөлийн 90 гаруй, байгууллагуудын 140 гаруй төлөөлөгчдөд арга зүйн зөвлөгөө өгөв.

Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тухай, Хүүхэд хамгааллын тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, хуулиар хамгаалагдсан эрх ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй, мөн хүчирхийллийн улмаас эрсдэлд байгаа иргэдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг ханган, нийгмийн ажил үйлчилгээг харьяалал харгалзахгүй үзүүлэх зорилгоор "Нэг цэгийн үйлчилгээний төв" орон нутагт байгуулагдаж, нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулав.

Хэрлэн сумын Иргэний хэргийн анхан шатны шүүхтэй хамтран Шүүхийн журмаар гэр бүл цуцлахад хүүхдийн асран хамгаалагч тогтоох, шинжээчийн дүгнэлт гаргах талаар хамтарсан уулзалт, ярилцлагыг зохион байгуулав. Уулзалтад Иргэний хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч, Шүүхийн Тамгын газрын дарга, холбогдох байгууллагын дарга, мэргэжилтнүүд, иргэний хэргийн анхан шатны шүүгч нар болон туслахууд оролцож тулгамдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэв.

Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Нийгмийн хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоог идэвхижүүлж, гэр бүлийн сайн сайхны төлөө хүн бүр манлайлан оролцохыг уриалж, төр, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх" зорилгоор "Орон

нутгийн хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайлал” VI чуулга уулзалтыг Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенцийн уриалгад нэгдэн хоёр үе шаттайгаар зохион байгуулав. Чуулганы эхний үе шатыг хөдөө сумдад зөвлөгөөн, хурал чуулга уулзалт хэлбэрээр 3400 гаруй эмэгтэйчүүд хамрагдаж санал хүсэлт, асуудлаа 5 чиглэлд тодорхойлон, нэгтгэж хүргүүлсэн бөгөөд сум тус бүрээс 10 төлөөлөгч нэгдсэн чуулганд оролцов.

Хоёрдугаар үе шат буюу нэгдсэн чуулганд орон нутгийн нийт 700 гаруй төлөөлөгчид оролцсон бөгөөд чуулганы үеэр “Эмэгтэйчүүдийн эв нэгдлийн хана” зургийг оролцогчдоор бүтээлгэн, эмэгтэйчүүд дуу хоолойгоо нэгтгэн оролцов.

Монгол Улсын Ерөнхий сайд, Хүүхэд төлөө үндэсний зөвлөлийн даргын 2019 оны 03 дугаар тогтоолын хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын сургалтын цагаар “Байгууллагын эцэг эхийн зөвлөл”-ийг байгуулан ажиллуулах арга зүйн зөвлөмж, сургалтыг зохион байгуулж, “Хандлага-өөрчлөлт” сэдэвт аймгийн Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөний үеэр төрийн байгууллагуудыг “Байгууллагын эцэг эхийн зөвлөл”-ийг байгуулж, “Бямба гарагийг гэр бүлдээ” уриалгыг дэмжин ажиллахыг уриалав.

“Хүүхдийн эрхийг хамгаалахад бүх нийтийн оролцоог нэмэгдүүлэх” зорилтот жилийн хүрээнд албан байгууллага, иргэд, эцэг эхчүүдэд “Гэр бүлийн боловсрол олгох”, “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх” сэдвээр сургалтуудыг зохион байгуулж байна. Энэ сард нийт 11 байгууллагын 1398 хүнд гэр бүлийн боловсрол, хүүхдийн хүмүүжлийн чиглэлээр мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан.

Залуучуудын хөгжил оролцооны талаар:

Өсвөр үе, залуучуудын хүмүүжил, төлөвшилд хувь нэмэр оруулан аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга барилд суралцуулах, мэдлэг чадвартай, хариуцлагатай, өөртөө итгэх зан үйл бүхий амьдрах үр чадвартай иргэн болгон төлөвшихөд нөлөөлөх зорилгоор амьдрах ухааны 12 модуль сургалтыг цувралаар зохион байгуулж байна. Энэ сард амьдрах ухааны чадвар олгох сургалтыг 2 байгууллагын 192 өсвөр үе, залуучууд болон байгууллагын ажилтан, албан хаагч, ажил хайгч, ажилгүй иргэдийг хамруулан зохион байгуулав.

Залуучуудыг авилга, ашиг сонирхлоос ангид байх, хувь хүний болон хотын соёлыг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулах, манлайлагч залуучуудыг бэлтгэн тэднээр дамжуулан өсвөр үе, залуучууд болон нийгэмд эерэг нөлөөлөл үзүүлэх зорилгоор “Бид Дорнодын залуус” зорилтот төслийг салбар бүрийн төлөөлөл 50 залуучуудыг оролцуулан 2 дахь жилдээ зохион байгуулав. Төслийн ажиллагаа 2018 оны 12 дугаар сараас 2019 оны 3 дугаар сарын хооронд зохион байгуулсан бөгөөд оролцогч залуучууд нийт 49 удаагийн үйл ажиллагаагаар 20000 гаруй иргэд, олон нийтэд эерэг нөлөөллийг хүргэж ажилласан байна. Тайлант хаалтын үйл ажиллагаанд 400 гаруй залуучууд оролцож, төсөлд оролцогчдын зүгээс зохион байгуулсан ажлын тайлантай танилцав.

Аймгийн Төв номын сантай хамтран “Орон нутгийн залуучуудад оюуны хөрөнгө оруулалт хийх, олон нийтэд ном унших сонирхлыг нэмэгдүүлэх, нөлөөлөх, эртэч зан үйлийг төлөвшүүлэх замаар, залуучуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй, зөв боловсон өнгөрүүлэх” зорилгоор “Номтой өглөө” уулзалтыг өнгөрсөн оноос зохион байгуулж хэвшээд байна. Уг уулзалтыг 2019 онд албан байгууллагуудад зохион байгуулж байгаа бөгөөд энэ оны эхний гурван сарын байдлаар нийт 6 байгууллагын 300 гаруй албан хаагчдад номын хэлэлцүүлгийг хийсэн.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Сургалт, зөвлөгөөн:

Аймгийн эрүүл мэндийн салбарын 2019 оны ээлжит удирдах ажилтны зөвлөгөөн болж, 2018 онд хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил, олсон ололт, анхаарах асуудал, 2019 онд дэвшүүлсэн зорилт, чиглэлийн талаар харилцан ярилцаж, санал бодлоо солилцон 2018 оны ажил үйлсээрээ шалгарсан эрүүл мэндийн байгууллагуудаа урамшуулан өргөмжлөл гардуулав. 2019 оны зорилтоо “Эрүүл мэндийн салбарт технологийн дэвшлийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх жил” хэмээн тодорхойлов.

Дэлхийн эмч нарын өдрийг угтан “Судлаач эмч 2019” эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурал болж, эмнэлзүйн болон нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр 12 илтгэл хэлэлцүүлэгдэж Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Эрчим эмчилгээ, сэхээн амьдруулах тасгийн эрхлэгч С.Дэлгэржаргалын илтгэл тэргүүн байранд шалгарав.

Монгол улсад Сувилагч мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн түүхт 90 жилийн ойд зориулсан сувилагч мэргэжилтэнг сурталчлах, мэргэжлээрээ бахархах “Сувилагчаа сонсьё” хэлэлцүүлэг, сувилахуйн тусламжийг чанартай хүргэх арга зүйн зөвлөгөө хосолсон сургалт 2019 оны 03 дугаар сарын 30, 31-ний

өдрүүдэд Дорнод аймагт амжилттай зохион байгуулагдав. Сургалтад Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Уламжлалт анагаах ухааны төв, Сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 128 сувилагч мэргэжилтэн хамрагдав.

Монголын Сумын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн холбооноос “Сүрьеэгүй ирээдүйн төлөө хамтдаа” сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж, 13 сумын багийн Засаг дарга, багийн бага эмч, лаборант нийт 120 хүн хамрагдав. Хөлөнбуйр, Булган, Сэргэлэн суманд сүрьеэгийн сорьц тээвэрлэлтийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зааварчилгаа өгч, дэмжлэгт хяналт хийсэн.

“Пневмококкийн эсрэг вакцин, халдварт саагийн эсрэг идэвхигүйжүүлсэн вакцинуудыг дархлаажуулалтанд нэвтрүүлэх” сэдэвт сургалтад анхан шатны эрүүл мэндийн төвүүдийн дарга, вакцинаатор бага эмч, сувилагч, бусад холбогдох мэргэжилтнүүд зэрэг нийт 74 хүн хамрагдав. Сургалтыг Халдварт өвчин судлалын үндэсний төв, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газрын сургагч багш нар зааж, дархлаажуулалтанд нэвтэрч буй пневмококкийн эсрэг вакцин, халдварт саагийн идэвхигүйжүүлсэн вакциныг нэвтрүүлэхэд анхаарах асуудал, хүйтэн хэлхээний горимын аюулгүй ажиллагаа, зорилтот бүлгийн хүүхдүүдийг дархлаажуулалтад хэрхэн хамруулах талаар санал солилцож, мэдээлэл сурталчилгааны 7 төрлийн 560 ширхэг ном, гарын авлагыг түгээсэн.

Засгийн газрын 224 дүгээр тогтоол, “Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны хүрээнд доорх ажлуудыг зохион байгуулав. Үүнд:

-“Цаг нь болсон” уриан дор өдөрлөгийн үйл ажиллагааг нээн, биеийн жингийн индекс тодорхойлон, цусны даралт үзэж, сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нийт 350 гаруй иргэдэд зохион байгуулав.

-Ерөнхий боловсролын сургуулиудын нийгмийн ажилтан, багш, ажилчид, сурагчдыг хамруулсан сургалтад нийт 172 иргэн оролцож, 2 төрлийн 130 ширхэг гарын авлага түгээсэн.

-Ерөнхий боловсролын сургуулийн дунд болон ахлах ангийн сурагчдын дунд “Сүрьеэгээр хэн ч өвдөж болно, бид нэг агаартай” сэдэвт эссе, гар зургийн уралдаан зохион байгуулж, Хэрлэн сумын 10, хөдөөгийн 4 сумын ерөнхий боловсролын сургуулийн нийт 120 хүүхдийн бүтээлийг хүлээн авч 8 бүтээлийг шалгаруулж, урамшуулав.

“Орон нутагт гэмтэл согогийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах” төслийг хэрэгжүүлэх зорилгоор Гэмтэл, Согог судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Т.Мөнхсайхан тэргүүтэй удирдлагууд болон эмч, сувилагч нарын баг Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Мэс засал, гэмтлийн тасаг, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмч, сувилагч нарт сургалт зохион байгуулав.

Нөлөөлөл, сурталчилгааны ажил:

“Давсны мэдээлэл сурталчилгааны 7 хоног”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд 9 үйл ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөн батлуулж, бүрэн хэрэгжүүлж ажиллав. Улс орон даяар “Давсыг хоолны цэснээс хасъя” уриатайгаар 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 4 дүгээр сарын 01-ний хооронд тэмдэглэн өнгөрүүлсэн.

Тамхины хяналтын тухай хуулийн зарим заалтыг хэрэгжүүлэх, туршилт судалгааны олон нийтэд түшиглэсэн судалгааг 4 байгууллагын 60 гаруй албан хаагчдад танилцуулан, судалгааг бөглөх ажлыг зохион байгуулав.

Нийгмийн эрүүл мэндийн төвд жирэмсэн эмэгтэйн жорын дасгалд 86 эх хамрагдаж, ахмадын биеэ тэтгэн чийрэгжүүлэх хийн дасгалд давхардсан тоогоор 38 ахмад настан хамрагдан үйлчлүүлж байна.

Биеийн тамир, спортын чиглэлээр:

“Эх орончдын өдөр”-т зориулсан улс, аймаг, сумын цолтой болон залуу бөхийн барилдааныг 03 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсан бөгөөд нийт 64 бөх зодоглосон.

Спортын мастер Д.Мөнхжаргал агсны нэрэмжит жүдо бөхийн өсвөр үеийн 2019 оны аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж 15 байгууллагын 278 тамирчид оролцов.

Халхголын ялалтын 80 жилийн ой, Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 98 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж буй үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд волейбол, ширээний теннис, сагсан бөмбөг, шатар, билльярд гэсэн спортын 6 төрлөөр явагдаж, нийт 13 байгууллагын 436 тамирчид оролцлоо.

Хүчний 3 төрөлтийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдөр явагдаж нийт 25 тамирчид оролцов.

Бадминтоны өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 03 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, 11 сургуулийн 186 тамирчид оролцов.

Аймгийн Хүүхдийн спортын 6 дугаар их наадмын эхний багцын үйл ажиллагаа 2019 оны 03 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд волейбол, сагсан бөмбөг, ширээний теннис, бадминтон гэсэн төрлүүдээр зохион байгуулагдаж, 20 байгууллалгын 650 гаруй тамирчид оролцжээ.

Ширээний теннисний өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдаж, 8 сургуулийн 77 тамирчид оролцлоо.

Мөн ширээний теннисний насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 03 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд болж, нийт 36 тамирчин оролцов.

Аймгийн хэмжээнд 3 дугаар сард нийт 8 удаагийн уралдаан, тэмцээнд 1752 тамирчин хамрагджээ.

Улс, бүсийн чанартай биеийн тамир, спортын уралдаан, тэмцээн:

Дорнод аймгийн баг тамирчид жүдо, самбо, кураш бөхийн спортын 3 төрлөөр улсын чанартай 5 тэмцээнд 142 тамирчин оролцож, 20 алт, 18 мөнгө, 42 хүрэл медаль хүртэж жүдо бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 80 тамирчин оролцох эрхээ аваад байна.

Нийгмийн даатгалын чиглэлээр:

Нийгмийн даатгалын үндсэн үзүүлэлт:

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын жилийн төлөвлөгөө 2019 оны 03 дугаар сард 6,03 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 3 дугаар сарын 31-ний байдлаар 7,91 тэрбум төгрөг төвлөрүүлэн 131,01 хувийн биелэлттэй ажиллав.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сангаар нь авч үзвэл;

(сая төг)

№	Нийгмийн даатгалын сан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Тэтгэврийн даатгалын сан	3994902,90	5010281,49	125,42
2	Тэтгэмжийн даатгалын сан	420174,50	564902,86	134,44
3	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	362562,00	598247,30	165,01
4	Ажилгүйдлийн даатгалын сан	78897,90	122576,95	155,36
5	Эрүүл мэндийн даатгалын сан	1179584,80	1612128,67	136,67
	ДҮН	6036122,10	7908137,27	131,01

Тэтгэврийн даатгалын сан:

Тэтгэврийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 125,42 хувиар биелүүлсэн бөгөөд уг сангаас нийт 12020 тэтгэвэр авагчдад 12,092 сая төгрөгийн тэтгэврийг олгосон.

Тэтгэвэр авагчдыг төрлөөр нь авч үзвэл:

- Өндөр насны тэтгэвэр - 8105 тэтгэвэр авагчдад 8319,8 сая төгрөг,
- Тахир дутуугийн тэтгэвэр - 2735 тэтгэвэр авагчид 2266,8 сая төгрөг,
- Тэжээгч алдсан тэтгэвэр - 624 тэтгэвэр авагчид 531,1 сая төгрөг,
- Цэргийн тэтгэвэр 556 тэтгэвэр авагчид 973,2 сая төгрөгийг тус тус олгов.

Тэтгэврийн тогтоолтын талаар :

Аймгийн хэмжээнд 2019 оны 03 дугаар сард нийт 86 иргэнд тэтгэвэр тогтоосон. Үүнээс:

- Өндөр насны тэтгэвэр 49,
- Тахир дутуугийн тэтгэвэр 30,
- Тэжээгч алдсаны тэтгэвэр 7-г тогтоолоо.

03 дугаар сард тогтоосон өндөр насны тэтгэврийг төрлөөр нь ангилбал:

- Цэргийн өндөр насны тэтгэвэр 1,
- Малчин нөхцөлөөр 3,

-Хүүхдээр 6,
-Хүнд нөхцлөөр 1,
-Бусад 38 нь хэвийн болон хувь тэнцсэн тэтгэвэр тогтоогдсон.
Мөн тахир дутуугийн тэтгэврээс:
Өндөр насны тэтгэвэрт 8,
Халамжийн сангаас:
-Тахир дутуугийн 10 тэтгэвэр авагч шилжиж ирсэн байна.

Тэтгэврийн өөрчлөлтийн талаар:

- Тэтгэвэр тогтоолгосон боловч 12 сараас доошгүй хугацаанд ажил, хөдөлмөр эрхэлж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн 14 тэтгэвэр авагчийн тэтгэврийг 355,6 мянган төгрөгөөр,
- Цагдаагийн албаны тухай шинэчилсэн хуулиар нэг жилийг нэг жил гурван сараар тооцуулан тэтгэврээ өөрчлөн тогтоолгохыг хүссэн 2 тэтгэвэр авагчийн тэтгэврийг 154,7 мянган төгрөгөөр тус тус өөрчлөн тогтоосон.

Тэтгэмжийн даатгалын сан:

Тэтгэмжийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 134,44 хувиар биелүүлсэн бөгөөд уг сангаас нийт 1063 иргэнд 597,9 төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Олгосон тэтгэмжийг төрлөөр нь авч үзвэл:

- Хөдөлмөрийн чадвар түр алдсны тэтгэмж 564 иргэнд 66,6 сая төгрөг,
- Жирэмсэн, амаржсаны тэтгэмж 391 иргэнд 383,3 сая төгрөг,
- Оршуулгын тэтгэмж 111 иргэнд 111,0 сая төгрөг болно.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан:

Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөө 165,01 хувиар биелүүлсэн бөгөөд уг сангаас:

- Тахир дутуугийн тэтгэвэр 62 иргэнд 78,9 сая төгрөг,
- Тэжээгч алдсан тэтгэвэр 15 иргэнд 17,4 сая төгрөг,
- Хөдөлмөрийн чадвар түр алдсны тэтгэмж 5 иргэнд 2,1 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Ажилгүйдлийн даатгалын сан:

Аймгийн хэмжээнд ажилгүйдлийн тэтгэмж 2019 оны 3 дугаар сард шинээр 84 даатгуулагчид 113,0 сая төгрөгийн тэтгэмжийг мэдээллийн санд шалгаж, үргэлжлүүлэн олгосон байна.

Хяналт шалгалтын талаар:

Нийгмийн даатгалын сангаас олгох Тэтгэмжийн даатгалын сан болон Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгосон хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн тогтоолт, олголтын эрх зүйн үндэслэл, анхан шатны баримтын бүрдэлд, төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүдээс олгосон эмнэлгийн хуудасны үндэслэл, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн төлөвлөлт, гүйцэтгэлд мониторинг хийн, шалган илэрсэн зөрчил дутагдлыг шийдвэрлэх ажлыг 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрөөс 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал 90 хоногийн хугацаанд зохион байгуулан ажиллаж байна. Шалгалтаар 2017-2018 онуудад олгосон хөдөлмөрийн чадвар алдалтын 820 иргэний материалд шалгалт хийж 77 иргэнд олгосон тэтгэмжийн үндэслэлийг дахин нарийвчилж шалгахаар болоод байна. Тус 77 иргэний хувьд ажилласан жилийг дахин нарийвчлан тодруулах, тахир дутуугийн тэтгэвэр авагч иргэний оношийн давхардалт байгаа эсэх, нэг

жилд олон удаагийн эмнэлэгт хэвтсэн үндэслэлийг шалгаж эхний байдлаар 3 иргэнд 188,998 төгрөгийн тэтгэмж илүү олгосон нь тогтоогдоод байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагын талаар:

2019 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлага 1016118,7 сая төгрөг байгаагаас төсөвт байгууллага 127734,8 мян төгрөг, аж ахуйн нэгж байгууллага 855435,7 мян төгрөгийн өр, авлага үүсгэсэн байна.

Аж ахуйн нэгж байгууллагыг шинээр нийгмийн даатгалд хамруулах ажлын төлөвлөгөөний дагуу 2019 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 10 байгууллагын 18 даатгуулагч, иргэнийг шинээр нийгмийн даатгалд хамруулан ажиллав.

Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагааны талаар:

Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс нь энэ сард нийт 4 удаа хуралдаж, 239 иргэний асуудлыг хэлэлцснээс шинээр тогтоосон 33, сунгасан 194, цуцалсан 11, хөдөлмөрийн нөхцөл сольсон 1, өндөр насны тэтгэвэр 5, сайжирсан 1, хяналтын хугацаа дууссан 5, буцаасан 5 иргэн байв. Шинээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийг өвчлөлийн байдлаар авч үзвэл: дотрын өвчин 15, хавдрын өвчин 3, мэдрэлийн өвчин 2, сэтгэцийн өвчин 5, гэмтлийн өвчин 9, сонсголд тэнцвэрийн эрхтний өвчин 4 байв.

Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах төв комиссоос Дорнод аймгийн Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисст дахин магадлах ажлыг 2019 оны 3 дугаар сарын 11-нээс 3 дугаар сарын 15-ны хооронд зохион байгууллаа. Дахин магадлалаар комиссын дотоод хяналт, албан хэрэг хөтлөлт, тайлан мэдээ хугацаанд нь гаргасан байдал, тэтгэврийн хувийн хэргийг комиссын мэдээллийн программтай тулган шалгасан байдал зэрэгт үнэлгээ дүгнэлт өгч ажиллалаа.

Шалгалтын явцад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан ердийн өвчний жагсаалт хэрэгжих явцад гарч буй анхаарах асуудал, санал, "Эмнэлгийн хуудас олгох журам"-ын талаар Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нартай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн дүнд эмч нарын гаргасан саналыг нэгтгэн төв комиист хүргүүлээд байна. Тахир дутуугийн тэтгэвэр авагч 38 иргэнийг дахин магадлаж, заалтын хугацаа нь дуусахад 3 иргэнийг цуцлахаар шийдвэрлэв.

Дотоод ажлын талаар:

"Танд ойрхон-Найрсаг үйлчилгээний жил" болгон зарласантай холбогдуулан иргэд даатгуулагчдад чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэн www.daatguulagch.ndaatgal.mn цахим лавлагааны вэбийг ажиллуулж эхлээд байна. Иргэд даатгуулагчид гар утас болон интернет орчноос орон зай цаг хугацаа үл хамааран нийгмийн даатгалын шимтгэл төлсөн лавлагааг авах боломжтой болсон.

"Нийгмийн даатгал" гар утасны аппликейшнийг сурталчлан таниулах аяныг 2019 оны 3 дугаар сарын 20-оос 4 дүгээр сарын 20-ныг хүртэлх хугацаанд төлөвлөгөө гарган томоохон аж ахуй нэгж байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажлын байранд ажиллах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлан иргэдийн гар утас, ухаалаг төхөөрөмжид аппликейшнийг суулгах, баталгаажуулах, нууц дугаарыг олгон ажиллаж байна.

Түүнчлэн иргэд даатгуулагчдад Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, сайн дурын даатгуулагчийн шимтгэлийг шуурхай төлүүлэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээ, нийгмийн даатгалын ач холбогдлын талаар мэдээлэх таниулах зорилготой явуулын үйлчилгээний удирдамжийн дагуу ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Угтах үйлчилгээг 1900 хүнд хүргэн ажиллав. Мөн үдийн цайны цагаар 341 иргэнд үйлчилсэн байна.

Иргэд, даатгуулагч, ажил олгогчдод нийгмийн даатгалын байгууллагын архиваас олгох лавлагааны үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх зорилгоор цахимаар болон хэлтэс хооронд солилцох үйл ажиллагааг зохион байгуулж эхлээд байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлтийн талаар:

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө, мэдээллээр хангах үйлчилгээ:

Ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 72 сурагч, иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгснөөс хөдөлмөрт бэлтгэх зөвлөгөө 16, хөдөлмөр эрхлэлтийн талаар 21, мэргэжил сонголтын талаар 35 иргэнд зөвлөгөө өгөөд байна. Зөвлөгөө мэдээлэлд хамрагдсан иргэдийг насны ангиллаар авч үзвэл 15-24 насны 37 иргэн, 25-34 насны 19 иргэн, 35-44 насны 11 иргэн, 45-54 насны 4 иргэн, 60-аас дээш насны 1 иргэн тус тус хамрагдсан байна.

Уул уурхайн олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй "Спек" ХХК-ийн ажлын байрны ярилцлагад орж буй иргэдэд өөрийгөө бэлтгэх, харилцааны ур чадвар, сэтгэл зүй, хувь хүний төлөвшил, Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн харилцаа, аюулгүй ажиллагааны мэдлэг олгох сургалтыг зохион байгуулав.

Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэний мэдээ:

Тайлант хугацаанд 76 аж ахуй нэгж, байгууллага, иргэнээс 64 сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирүүлсний дагуу 259 иргэнд ажлын байр санал болгож 84 иргэнийг байнгын ажлын байранд зуучлаад байна. Эдийн засгийн салбараар авч үзвэл хөдөө аж ахуй 5, уул уурхай 36, боловсруулах 8, боловсрол 18, эрүүл мэнд 5, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 12 иргэн тус тус зуучлагдсан байна. Ажилд зуучлах үйлчилгээний хүрээнд шинээр нээгдэж буй уул уурхайн "Спек" ХХК-ийн нээлттэй ажлын байранд 65 иргэнтэй ажлын ярилцлагыг зохион байгуулсанаас 14 иргэн ажлын байранд тэнцсэн.

Бүртгэлтэй ажил хайгч, ажилгүй иргэний хөдөлгөөний мэдээ:

Мэдээллийн санд 1413 ажил хайгч иргэн бүртгэлтэй байна. Үүнээс эмэгтэй 591. Ажил хайж буй иргэдийн боловсролын түвшингээр авч үзвэл 51,1 хувийг бүрэн дунд боловсролтой иргэд, 19,3 хувийг тусгай, техникийн боловсролтой иргэд, 7,8 хувийг суурь боловсролтой иргэд, 20,1 хувийг дээд боловсролтой иргэд эзэлж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Бүгд Найрамдах Солонгос улсын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам хоорондын "Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо"-ны дагуу ажилтан илгээх болон хүлээн авах тухай "Харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн дагуу 15 дахь удаагийн Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын бүртгэлийг 3 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд зохион байгуулж, 127 иргэнийг бүртгэж, мэдээ тайланг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлсэн.

Хөдөлмөр, эрхлэлтийн төсөл хөтөлбөрийн хүрээнд:

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн анхдугаар хуралдаанаар 2019 онд хэрэгжих төсөл, хөтөлбөрийн чиглэлийг тодорхойлж баталсан.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1. Гэрээт малчин өрх авч ажиллуулах хүсэлтэй, тухайн өрхийн малыг богд шилжүүлснээр 600 болон түүнээс дээш тооны малтай малчин ажил олгогч өрхийн судалгаа,

2. 18-45 насны 2-оос доошгүй гишүүнтэй, малгүй болон бог малд шилжүүлснээр 200 хүртэлх толгой малтай малчин өрхийн судалгааг аймгийн хэмжээнд авч нэгтгэсэн. Судалгааны үр дүнг Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн анхдугаар хуралдаанд танилцуулж, сумдад хэрэгжих хөтөлбөрийн хуваарийг батлуулав. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан төсөл хөтөлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөр хэлэлцүүлэн

чиглэлийг батлуулж, сонгон шалгаруулалтыг 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаатай зарлаад байна.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Нийгмийн халамжийн тэтгэвэр:

- Ахмад настны тэтгэвэрт 92 хүн хамрагдаж 15,3 сая төгрөг,
- Хөгжлийн бэрхшээлтэй 1339 иргэнд 217,5 сая төгрөг,
- Одой 6 иргэнд 1,0 сая төгрөг,
- Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны 448 хүүхдэд 79,2 сая төгрөг нийт 1885 иргэн хамрагдаж, 313,0 сая төгрөг зарцуулсан байна.

Нийгмийн халамжийн тэтгэмж:

Асаргааны тэтгэмж:

- Ахмад настныг асарч байгаа 666 иргэнд 46,6 сая төгрөг,
- Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асарч байгаа 293 иргэнд 20,6 сая төгрөг,
- Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 448 иргэнд 31,2 сая төгрөг,
- Бүтэн өнчин хүүхдийг үрчилж авсан 3 иргэнд 228,0 мянган төгрөг,
- Бүтэн өнчин хүүхдийг асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа 94 иргэнд 7,1 сая төгрөг,
- Бүтэн өнчин хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа 11 иргэнд 912,0 мянган төгрөг,
- Ганц бие ахмад настныг асрамжилж байгаа 5 иргэнд 380,0 мянган төгрөг, нийт 1520 иргэнд 107,2 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмж:

- Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны 287 хүүхдэд 46,1 сая төгрөг,
- Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 41 иргэнд 2,4 сая төгрөг,
- Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан 66 иргэн тэтгэмжид 3,9 сая төгрөгийг тус тус зарцуулж, нийт 394 иргэнд 52,4 сая төгрөг зарцуулсан байна.

Эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж:

- Жирэмсэн эхчүүдийн тэтгэмжид 762 иргэнд 26,5 сая төгрөг,
- 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид 4467 эхэд 220,3 сая төгрөг,
- Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид 281 иргэнд 87,7 сая төгрөг, нийт 5510 иргэнд 334,5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Улсын төсвөөс олгосон тэтгэмж, тусламжид:

- Эхийн алдар 1, 2 дугаар зэргийн одонтой 67 иргэнд нийт 7,6 сая төгрөг,
- Насны хишигийг 28 иргэнд 2,0 сая төгрөгийг тус тус олгосон байна

Ахмад настанд олгох тусламж, хөнгөлөлт:

- Ахмад настны протез, ортопедийн хэрэгсэлд 36 ахмад настанд 8,0 сая төгрөг,
- Ахмадын зориулалттай амралт сувилалд 30 ахмад настан 4,2 сая төгрөг, 10,2 сая төгрөгийн хөнгөлөлтөд тус тус хамруулсан.

Алдар цолтой ахмад настанд улсын төсвөөс олгож байгаа тусламж, хөнгөлөлт:

Улсын ударник, гавьяат, төрийн өндөр албан тушаал хашиж байсан 26 ахмад настанд улсын төсвөөс 4,7 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлтөд тус бүр хамруулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тусламж, хөнгөлөлт:

- Протез, ортопедийн хэрэгсэлд 10 ахмад настанд 1,1 сая төгрөг,

-Насанд хүрсэн бүрэн хараагүй иргэний харилцаа холбооны зардал 262 иргэнд 6,8 сая төгрөгийг зарцуулсан.

Өрхийн нэгдсэн мэдээллийн нэгдсэн сан, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ хүүхдийн мөнгөний талаар:

2019 оны 3 дугаар сарын 1-ний өдөр 212 өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны үнэлгээ бодогдсон. Улмаар мэдээлэл зөрүүтэй нийт 110 өрхийн мэдээлэл жагсаалтаар цахим байдлаар ирсэн. Сумдын баталгаажуулах өрхийн жагсаалтыг хүргүүлж, улмаар Хэрлэн сумын хэмжээнд мэдээлэл зөрсөн 60 өрхтэй утсаар холбогдож, лавлагаа баримтын авчран мэдээллээ баталгаажуулах шаардлагатай байгаа талаар зөвлөгөөг өгсөн. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 13-ний өдрийн А/18 дугаар тушаал болон өрхийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэлтэд хяналт шалгалт хийх ажлын удирдамжийн дагуу 2019 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 03 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд жагсаалтаар ирсэн 294 өрхийн мэдээллийг эхний болон сүүлийн судалгааны асуулгатай тулгаж, мөн 136 өрхөөр зочлон мэдээлэл цуглуулж, ажлын гүйцэтгэл, тайлан мэдээг хавсралтын дагуу хийж хүргүүлсэн.

Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа:

Дорнод аймгийн хэмжээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг 14 сумын 2519 өрхийн 7431 том хүн, 6325 хүүхдэд нийт 13756 хүнд хүргэж 2019 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 169,496,000 мянган төгрөгийг зарцуулаад байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1 дэх заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/13 дугаар тушаалаар батлагдсан "Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний"-ний журмын дагуу хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авах эрх үүсэн 15 өрхийг шинээр хамруулж Төрийн банкны хүнсний эрхийн бичгийн цахим карт захиалж өгсөн. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлэх шинээр гэрээ байгуулсан хүнсний дэлгүүрүүдэд хэрэгжилтийн талаар мэдээлэл өгч ажиллалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар:

"Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр" болон, аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих салбар зөвлөлийн 2019 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг боловсруулан батлуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс энэ сард 1 удаа хуралдаж, 10 хүүхдийн асуудлыг хэлэлцэж 5 хүүхдийн байнгын асаргааг сунгаж, 3 хүүхдийн байнгын асаргааг шинээр тогтоож, 2 хүүхдийн байнгын асаргааг цуцалж, 10 хүүхдийг эрүүл мэндийн үйлчилгээнд тогтмол хамрагдаж байх шийдвэрийг гаргаж эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав. Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран энэ онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Зорилтот өрхийн хөгжил хамгааллын чиглэлээр:

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас 2019 оныг "Зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан зорилтот өрхийн гишүүн иргэдийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээний чиглэлийг танилцуулан өрх сонгох, өрхийн үнэлгээ хийх, өрхийн дэвтэр хөтлөлтийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний талаар:

Сэргээн засах үйлчилгээ:

Сэргээн засах үйлчилгээгээр өвчин эмгэг, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилган амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн тусламж үйлчилгээг “Дойт баян бүрд” ХХК-ийн дэргэдэх Мэдрэл, сэргээн засах эмнэлэг нь сэргээн засах үйлчилгээг орчин үеийн болон уламжлалт гэсэн 2 аргаар ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Энэхүү үйлчилгээнд 13 ахмад настан, 2 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилгээ үзүүлж 1,462.5 төгрөгийг зарцуулсан.

Өдрийн үйлчилгээний чиглэлээр:

Аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй эцэг эхийн холбоо” төрийн бус байгууллага нь өдрийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаатай хүүхдүүдэд үзүүлж байна. 15 байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлж 630,0 мянган төгрөгийг зарцуулсан.

Зүүн бүсийн асрамж, үйлчилгээний төвийн чиглэлээр:

“Койка” Олон Улсын байгууллагын сайн дурын ажилтан Квон Миаэтэй хамтран ахмад настны хөгжлийн үйлчилгээг өдөр бүр үзүүлж байна. Өглөө бүр ахмадуудын дунд хөдөлгөөний дутагдлаас сэргийлсэн гимнастик, мэдрэлийн эд, эс сэргээх дасгал, гарын массаж зэрэг үйлчилгээг үзүүлэхээс гадна хөгжөөнт тоглоом, уралдаан, тэмцээн тогтмол зохион байгуулж байна.

ТАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Мал аж ахуйн чиглэлээр

“Мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улс, орон нутгийн салбарын бодлогыг танилцуулах, мал аж ахуйн салбарт тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх, малын ашиг шимийг нэмэгдүүлэх, бэлчээрийг зохистой ашиглах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зорилгоор “Малчдын зөвлөгөөн-2019” арга хэмжээг 03 дугаар сарын 26-ны өдөр зохион байгууллаа. Зөвлөгөөнд ХХААХҮ-ийн дэд сайд Ж.Сауле, Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн болон аймаг, сумдын удирдлага, сумдын ЗДТГ-ын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүд, Монгол Улсын Гавъяат малчид, улс, аймаг, сумын аварга болон залуу малчдын төлөөлөл нийт 450 хүн хамрагдсан.

Зөвлөгөөний үеэр Хөдөө аж ахуйн салбарт 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын талаарх мэдээлэл, Хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримталж байгаа бодлогын хэрэгжилт, Мал амьтаны эрүүл мэндийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашдын зорилт, Хөдөө аж ахуйн салбарын ажиллагсад хамааралтай нийгмийн даатгалын хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлтүүд, Иргэнд өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар эзэмшүүлэх ажлыг эрчимжүүлэх аяны хэрэгжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, ач холбогдол, Цаг уурын төлөв байдал, Малчдын хөдөлмөр эрхлэлт, Залуу малчин хөтөлбөрийн танилцуулга, Малчдын эрүүл мэнд, цаашид анхаарах асуудал, Малчдын хүүхдийн боловсролын талаар, Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд малчдын оролцоо, Уул уурхайн харилцаанд малчдын оролцоо, Ой хээрийн түймэрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр, Эрчимжсэн мал аж ахуй болон жижиг дунд үйлдвэрлэлийн талаар, Бэлчээрийн төлөв байдал зэрэг илтгэлүүдийг тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч малчдын санал бодлыг сонсож, хариулт өгч ажиллалаа.

Мал төллөлт: Аймгийн хэмжээнд нийт малын 44,0 хувь буюу 1048091 толгой хээлтэгч мал байна. Үүнээс: Ингэ 2291 толгой буюу 0,2 хувь, гүү 88328 толгой буюу 8,4 хувь, үнээ 94444 толгой буюу 9 хувь, эм хонь 539692 толгой буюу 51,4 хувь, эм ямаа 323336 толгой буюу 30,8 хувийг тус тус эзэлж байна.

Төл бойжилт: Аймгийн хэмжээнд 1,048,091 толгой хээлтэгч төллөхөөс 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 21059 толгой хээлтэгч буюу нийт хээлтэгчийн 2,0 хувь нь төллөөд байна.

Төл: Ботго 69 толгой, Унага 1440 толгой, тугал 3439 толгой, хурга 9578 толгой, ишиг 7010 толгой нийт 21536 толгой төл гарсан байна.

Төлийн хорогдол: Үүнээс: Унага 19 толгой, тугал 62 толгой, хурга 173 толгой, ишиг 178 толгой нийт 432 толгой төл буюу 1.6 толгой төл мал хорогдоод байна.

Бойжиж буй төл мал: Аймгийн хэмжээнд 21059 толгой хээлтэгч мал төлөлснөөс 21104 толгой төл буюу 98,4 хувь нь бойжиж байна. Үүнд: Ботго 70 толгой, унага 1421 толгой, тугал 3377 толгой, хурга 9405 толгой, ишиг 6832 толгой нийт 21104 толгой төл мал бойжиж байна.

Том малын зүй бүс хорогдол: Аймгийн хэмжээнд 2019 оны 03 дугаар сарын байдлаар 683 толгой мал хорогдсон байна. Үүнд: Адуу 87 толгой, Үхэр 96 толгой, хонь 219 толгой, ямаа 319 толгой мал хорогдоод байна.

“Ноос боловсруулах үйлдвэрлэлийн өртөгийн сүлжээ” сургалтанд төлөөлөгч хамруулсан тухай: Монголын Ноосон Бүтээгдэхүүн Үйлдвэрлэгчдийн Холбоо, МҮХАҮТ ГХАҮТХ хоорондын Хамтын Ажиллагааны “Нэмүү өртгийн сүлжээг дэмжих” Төсөл хамтран Орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх, малчид болон түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн үргүй зардлыг бууруулах, түүхий эд бэлтгэлийн тогтолцооны үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотноо 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдөр “Ноос боловсруулах үйлдвэрлэлийн өртөгийн сүлжээ” сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд 21 аймгийн 21 мэргэжилтэн, ноосны 40 итгэмжлэгдсэн төлөөлөгч нийт 61 хүн хамрагдсан. Дорнод аймгаас Булган сумын “Эсгий дулаалга” хоршооны дарга Г.Бямбадорж, Баяндун сумын “Нутгийн хөх чулуу” хоршооны дарга М.Мөнхзориг нарыг хамруулсан.

Сургалтаар Ноос боловсруулах үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээ, Монгол Улсын түүхий эд бэлтгэлийн тогтолцоо ба түүхий эдийн мэргэжилтэний эрэлт хэрэгцээ болон ноос, ноолуурын хялгас ялгах, шивмэл эсгий чиглэлээр үйлдвэрлэл эрхэлдэг “Нэхээсгүй эдлэл” ХХК, Ээрмэл, утас, хивсний чиглэлээр үйлдвэрлэл эрхэлдэг “Улаанбаатар хивс” ХХК, ноосон даавууны чиглэлээр үйлдвэрлэл явуулдаг “Блю скай кашмер” ХХК-уудын үйл ажиллагаатай танилцаж туршлага судалсан.

ХХААХҮЯ-ны Малын үржил бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар Улаанбаатар хотноо Улсын их хурлын 2017 оны 82 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, мал сүргийн генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх, мал үржүүлэг, технологийн ажлыг нэгдсэн төлөвлөгөөний дагуу технологийн хугацаанд хийж гүйцэтгэх зорилгоор “Мал үржүүлэг, технологийн ажлын нээлт”-ийг 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдөр ХХААХҮЯ-нд хурлын танхимд зохион байгуулагдлаа. Нээлтийн үйл ажиллагаанд 21 аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга нар хамрагдсан.

Нээлтийн үйл ажиллагаанд Мал үржүүлэг, техникологийн ажил үйлчилгээ-Түүхэн замнал,-Мал генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх, Биотехнологийн олотыг нэвтрүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ, малын үржлийн ажлын технологт хугацаа цаашид анхаарах асуудал, Орон нутаг байгаа Цөм сүрэг үржлийн төвийн малд үзлэг ангилалт болон хянан баталгаа хийх, ангилалт болон хянан магдалгааг 14 аймагт технологт хугацаанд хийх мэдээ тайлан болон холбогдох бичиг баримтыг журмын дагуу боловсруулан тайлагнах, малын бүртгэлжүүлэлтийг 7 аймагт хийх, Дорнод аймгийн хувьд Барга, Буриад Дорнод талын мухар улаан үхэрт ангилалт болон удам зүйн үнэлгээг технологт хугацаанд хийх талд аймаг орон нутаг анхаарах, Мөн сумдын хөдөө аж ахуйн тасаг болон үржлийн нэгжид ажиллаж байгаа мэргэжлийн мал зүйч нарыг мэргэшүүлэх сургалтанд хамруулах, мал үржлийн тоног төхөөрөмжөөр хангах зэрэг арга хэмжээг авч ажиллахаар төлөвлөж, үүрэг чиглэл өглөө.

Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, “Бэлчээр, хадлан, тэжээлийн талаар баримтлах бодлого”-ын 5.1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Уур амьсгалын өөрчлөлт, эрэлт хэрэгцээнд тулгуурлан, бэлчээр, хадлангийн талбайг хамгаалах, сайжруулах, талхагдсан бэлчээрийг нөхөн сэргээх, бэлчээрийн үлийн цагаан оготныг устгаж бэлчээрийг хамгаалах замаар мал аж ахуйн эрсдлийг бууруулах зорилгоор “Бэлчээрийн үлийн цагаан оготнотой байгаль орчинд халгүй аргаар тэмцэх” сургалтыг 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгууллаа. Сургалтанд 11 сумын Хөдөө аж ахуйн тасгийн 14 мэргэжилтэн хамрагдсан.

Сургалтыг Бэлчээр, тэжээл, усан хангамж хариуцсан мэргэжилтэн Ч.Шинэцэцэг удирдан зохион байгуулж, сургалтын удирдамжийн дагуу Бэлчээрийн үлийн цагаан оготнотой байгаль орчинд халгүй

аргаар тэмцэх ажлыг хэрхэн зохион байгуулах, тайлан мэдээ ирүүлэх, цаашид анхаарах асуудлын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, үүрэг чиглэл өгч ажиллаа. Сургалтын явцад Бэлчээрийн хөнөөлт мэргэгчидтэй байгаль орчинд халгүй аргаар тэмцэх зөвлөмж, гарын авлагыг өгч ажилласан.

Сүү үйлдвэрлэгч аж ахуй нэгж, иргэдийн эрх ашгийг хамгаалах, Хэрэглэгчдийг хүнсний эрүүл ахуй стандартад нийцсэн экологийн цэвэр сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах зорилгоор 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Дорнод аймгийн "Сүү үйлдвэрлэгчдийн дэвшил холбоо" байгуулан ажиллаж байна. Энэхүү холбоондоо Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуй нэгжүүд хамрагдаж байна. Дорнод аймгийн "Сүү үйлдвэрлэгчдийн дэвшил холбоо"-ны II уулзалтыг Хас банкны хурлын танхимд 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Уулзалтанд эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж нийт 11 төлөөлөл оролцлоо.

Газар тариалангийн чиглэлээр:

Энэ онд 7 сумын нутагт 72,389 га тариалангийн газар эзэмшигч үр тарианы 20 аж ахуй нэгжүүд нийт 40,9 мянга га тариалалт хийх бөгөөд үүний 19,6 мян.га-д улаан буудай, 8,2 мянга га-д бусад үр тариа, 700 га-д эмийн ургамал, 4,800 га-д тосны ургамал, 7600 га-д малын тэжээлийн ургамал тус тус тариалахаар төлөвлөөд байна. Дээрх тариалалтын 68,7% нь уриншинд тариалалт хийж үлдсэн хувьд хаврын хагалгаа гуурсанд тариалалтыг хийж 26231 га-д уриншийн боловсруулалт хийхээр төлөвлөөд байна. Үр тарианы аж ахуй нэгжүүд 1537 тн улаан буудайн үрийн нөөцийг өнгөрсөн оны ургацаас бүрдүүлсэн бөгөөд 1591 тн үр дутагдах төлөвтэй байна. Атар газар эзэмшсэний 60 жилийн ойн хүрээнд 13 сумдаас 310 ахмад тариаланчдын судалгааг гарган ХХААХҮ-ийн яаманд хүргүүлсэн. Мөн 2019 оны тариалалтын урьдчилсан төлөвлөгөөг тариалан бүхий сумдаас татан авч нэгтгэн ажиллаж байна.

Монгол улсад Атар газар эзэмшсэний түүхт 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 76 дугаар тогтоолын дагуу тус ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх тухай ахмад тариаланчид, мэргэжилтнүүдтэй санал солилцох арга хэмжээг зохион байгуулсан. Нийт 16 ахмад тариаланч, тэргэжилтэн нар оролцсон.

Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр:

"Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье" арга хэмжээ зохион байгуулсан тухай: Засгийн газрын 2015 оны 353 дугаар тогтоолоор батлагдсан "Давсны хэрэглээг бууруулах" үндэсний стратеги, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн хамтарсан А/119/А/355 тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор "Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье" арга хэмжээний 2-р шатны арга хэмжээг 2019 оны 03-р сарын 07-нд, 03-р сарын 21 нд тус тус уулзалт зохион байгуулж ажилласан. Сургалтаар тухайн жилдд хийх ажлын төлөвлөгөө болон "Давс багатай хүнс сонгох нь таны эрүүл мэндэд" сэдвээр мэдээлэл өгсөн. Мөн МХГ-аас сургалтанд хамрагдсан аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний давсны хэмжээ тогтоох шинжилгээг үнэ төлбөргүй зохион байгуулахаар болсон. Сургалтанд аж ахуйн нэгж, эмнэлэг, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн тогооч 29 хүн оролцсоноос "Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье" арга хэмжээнд оролцохоор 20 аж ахуйн нэгж, байгууллага оролцохоор бүртгүүлээд байна.

Эрүүл-хүнс хэлэлцүүлэг зохион байгуулсан тухай: Аймгийн Засаг даргын 2017 оны А/244 дүгээр захирамжаар байгуулагдсан Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөл дээрх тэмдэглэлт өдрийг тохиолдуулан "Эрүүл- хүнс" сэдэвт хэлэлцүүлэг 2019 оны 03 дугаар сарын 25-нд зохион байгуулсан. "Эрүүл-хүнс" арга хэмжээний зорилго нь Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт орон нутагт ямар төвшинд байгаа болон иргэд, олон нийтэд эрүүл аюулгүй хүнсний талаар ойлголт өгөх, хүнсний үйлдвэрлэл эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдэд тулгамдаж буй асуудлыг сонсож хэлэлцүүлэхэд оршино.

Уг арга хэмжээг ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Мэргэжлийн хяналтын газрын Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч, Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга нар холбогдох мэдээлэл танилцуулж, хэлэлцүүлэгт оролцсон хүнс үйлдвэрлэгч иргэд, аж ахуйн нэгжид тулгамдаж буй асуудлыг хэлэлцэж, саналыг сонслоо.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлээр:

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу Засаг даргын орлогчын баталсан удирдамжийн дагуу 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдөр “Зөгийн аж ахуй эрхлэгчдийн анхдугаар зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан. Зөвлөгөөнд урилгаар Монголын зөгийчдийн холбооны дээд зөвлөлийн дарга Б.Занданхүү, доктор Х.Отгонбилэг, Халхгол, Баян-Уул, Чойбалсан, Хэрлэн сумын зөгийн аж ахуй эрхлэгчдийн төлөөлөл 33 иргэн, аж ахуй нэгж оролцсон.

Төрөөс Зөгийн аж ахуйн талаар баримталж буй бодлого, дэмжлэг, Монголын Зөгийн аж ахуйн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, Монгол орны балт, тоост ургамлын нөөц, зөгийн бэлчээр, Зөгийн аж ахуйн бүтээгдэхүүн, тэдгээрийн ач холбогдол, хэрэглэх энгийн аргууд, Зөгийн арчилгаа, маллагааны технологи, эрүүл ахуй, Зөгийн бал хураах технологи, өвчин, хортонтой тэмцэх арга, зөгийн балны худалдаа, экспорт, нэмүү өртгийн сүлжээ ба кластерийн тогтолцоо зэрэг сэдвээр мэдээлэл хийж, тулгамдаж буй асуудал цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар өргөн хүрээтэй зөвлөлдлөө. Мөн аймгийн Зөгийчдийн холбоо нь хамтран ажиллах ажлын төлөвлөгөөний төслийг гарган зөвлөгөөн дээр танилцуулан санал солилцлоо.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Европын холбоо, Чехийн “Пипл ин нийд” ОУБ, Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоотой хамтран 21 аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг 2019 оны 3 дугаар сарын 12-13-ны хооронд зохион байгууллаа. Сургалтаар Сум хөгжүүлэх сангийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр Иргэний тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, гэрээний эрх зүй, үүргийн эрх зүй, гэрээнд тусгах зүйл, гэрээний биелэлт хангуулах, гэрээний хугацаа дуусахад ямар хугацаанд шүүхэд хандах ёстой, барьцаа хөрөнгийн үнэлгээ, барьцааны гэрээг хэрхэн баталгаажуулах зэрэг хууль эрх зүйн талаар болон Сум хөгжүүлэх сангийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгэхтэй холбоотой программ хангамжийг ашиглах, бүртгэх, цаашид анхаарах талаар мэдээлэл танилцуулсан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Глобал Коммунитс ОУБ хамтран 2019 оны 3 дугаар сарын 14-ний өдөр 21 аймаг болон нийслэлийн хоршооны асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулан “Хоршооны хөгжлийн үнэлгээг CPI аргачлалаар хийх” сургалтыг хамтран зохион байгуулав. Сургалтаар хоршоодын бизнесийн үйл ажиллагаанд засаглал, санхүү, үйлдвэрлэл, маркетинг, гишүүнчлэл гэсэн 5 үндсэн чиглэлээр хоршоодод нийтлэг тулгамдаж буй асуудлыг тодруулан, тэдгээрийн үйл ажиллагааг сайжруулах, зөвлөмж бэлтгэх, хоршоодын гишүүд болон удирдлагын багийн өөрийн хоршоог үнэлэх чадварыг оролцогчдод эзэмшүүлсэн. Сургалтын хугацаанд сум хөгжүүлэх сангийн программ, зээлийн батлан даалтын сан, хөнгөнт үйлдвэр, ахуйн үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, Нэг сум – Нэг хоршоо, Нэг суурин- Нэг бахархал аян, Хоршооны салбарт хэрэгжиж буй төрийн бодлого, Иргэний хууль зэрэг сэдвүүдээр сургалт мэдээлэл авсан.

Засаг даргын тамгын газар, MERIT төсөлтэй хамтран “Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах” Бизнесийн удирдлага, менежментийн сертификаттай сургалтыг 2019 оны 03 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд зохион байгууллаа. Санхүүгийн бүртгэл, маркетинг борлуулалт, бизнесийн хууль, эрх зүй зэрэг 48 цагийн мэдлэг эзэмшүүлэх сургалтад 8 сумын жижиг, дунд бизнес эрхлэгч, холбогдох албаны мэргэжилтэн нийт 30 гаруй хүн хамрагдлаа. Сумдын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдэд сум хөгжүүлэх сангийн мэдээлэл Монгол банкруу татагдах болсонтой холбогдуулан сангийн програм, зээлийн гэрээнд тусгах заалт, иргэдэд мэлээл хүргэх болон зээлийн батлан даалтын сангийн мэдээллийг өгч ажиллалаа.

Мал эмнэлгийн чиглэлээр:

Аймгийн Засаг даргын 2019 оны А/46 дугаар захирамж, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 119 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу аймгийн хэмжээнд 2019 оны 02 дугаар сарын 12-ноос 03 дугаар сарын 15-ны хугацаанд мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 14 сумын 65 багийн 1506.6 мянган толгой малд урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахаас 94.5 хувийн гүйцэтгэлтэй зохион байгуулан явуулж. Уг ажилд нийт 51 ажлын хэсэгт, 45 малын эмч, 91 мал баригч, 49 жолооч,

22 хяналтын ажилтан, 18 малын бага эмч, хилийн тусгай хүчний 275, 306, 198, 032 дугаар анги нэгтгэлүүд дайчлагдан ажилласан. Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээтэй холбогдуулан Биокомбинат эмийн үйлдвэрээс бог малын шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх 29,3 мянган тун вакциныг татан авч сумдад захиалгын дагуу хуваарилан олгосон. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг 10 суманд зохион байгуулна.

Аймгийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/46 дүгээр захирамж, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 119 албан тоот зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Баянтүмэн, Булган, Хэрлэн, Чойбалсан сумдын Мал эмнэлгийн тасгуудтай хамтран 17 малчин өрхөд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг орон нутгийн ард иргэдэд таниулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, улс орон нутгийн төсвөөс санхүүжүүлж буй дархлаажуулалтын гүйцэтгэл, технологийн мөрдөлт, вакцин зарцуулалтанд хяналт тавьж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан хяналт тавьж ажилласан. Мал эмнэлгийн газрын даргын өгсөн үүрэг чиглэлийн дагуу сумдад ажиллаж байгаа улсын байцаагч, тархвар зүйч нартай 2019 оны үр дүнгийн гэрээг хийж гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. Аймгийн Мал эмнэлгийн газраас “Нэгдсэн тогтолцоо-Хамтын ажиллагаа” сэдэвт мал эмнэлгийн анхдугаар зөвлөгөөнийг 2019 оны 3 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд зохион байгуулсан.

Мал эмнэлгийн салбарын анхдугаар зөвлөгөөнд аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, ХБХОХ-ийн дарга Х.Энх-Отгон, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Прокурорын газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, Мал эмнэлгийн газар, сумдын Мал эмнэлгийн тасгууд, хувийн хэвшлийн мал эмнэлгийн нэгжүүд, Хилийн 0132, 0306, 0275, 0198 дугаар ангиудын малын эмч мэргэжилтнүүд нийт 117 хүн оролцлоо. Зөвлөгөөний 2 дахь өдрийн төрөлжсөн сургалтын хүрээнд МЭТ-ийн дарга, Хилийн ангийн Хөдөө аж ахуйн тасгийн дарга, 42 мал эмнэлгийн нэгжүүдийн захирал нартай хамтран ажиллах гэрээг байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллалаа.

Мал эмнэлгийн ерөнхий газраас 21 аймгийн Мал эмнэлгийн газрын тархвар судлаач эмч нарыг газар зүйн байршил тогтоох ARCGIS сургалтыг 2019 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс 3 дугаар сарын 17-ны өдрийг дуустал хугацаанд Улаанбаатар хотод зохион байгуулсан. Сургалтанд аймгийн МЭГ-ын Зооноз халдварт өвчин, тандалт хариуцсан малын эмч Э.Пүрэвдорж хамрагдсан. Мал эмнэлгийн салбарт ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор Мал эмнэлгийн ариун цэврийн лабораторийн шимэгч судлалын шинжээч эмч Ц.Оюунтуулыг УМЭАЦТЛ-т 02 дугаар сарын 28-наас 3 дугаар сарын 04-нийг хүртэл хугацаанд Паразит, молекул биологийн сургалтанд хамруулсан.

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ҮЙЛДВЭР ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Байгаль орчны чиглэлээр:

Дорнод аймаг 2019 оныг “Аялал жуулчлалыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан өвлийн аялал жуулчлалын хаалт, зуны аялал жуулчлалын нээлтийн үйл ажиллагааг 3 дугаар сарын 14-ны өдөр зохион байгуулсан. Зорилтот жилийн нээлтийн үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат, аймгийн ЗДТГ-ын дарга П.Бат-Өлзий, аймгийн ИТХ-ын төлөөлөгч, аялал жуулчлалын бодлогын хорооны дарга Р.Зоригтбаатар болон агентлаг, хэлтэс, 14 сумдын удирдлагууд, иргэд оролцсон. Нээлтийн үйл ажиллагааны хүрээнд аймгийн ИТХ-ын байгаль орчин аялал жуулчлалын бодлогын хорооны гишүүд, сумын Засаг дарга нар, аялал жуулчлалын асуудал хариуцсан ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулагдаж, Бэлэг дүрсгал үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж болон боловсон ариун цэврийн байгууламжийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдсан. “Орон нутгийн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээг дэмжих жил-2018” зорилтот жилийн тайлан, “Аялал жуулчлалыг дэмжих жил-2019” зорилтот жилийн хүрээнд зохион байгуулах болзолт уралдааныг аймгийн ЗДТГ-ын дарга П.Бат-Өлзий танилцуулсан.

- Аймгийн шилдэг аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж шалгаруулах
- “Аялал жуулчлалыг дэмжигч сум” шалгаруулах

- “Аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүнийг шинээр санаачлан хэрэгжүүлсэн иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгжийг шалгаруулах
- Аймгийн аялал жуулчлалын уриа үг, лого бүтээх
- Аймгийн Аялал жуулчлалыг сурталчлах видео контент бүтээх
- Аймгийн түүх соёлын дурсгалт зүйлсийн онцлогийг харуулсан бэлэг дурсгалын зүйлс бүтээх
- “Тал нутгийн дөрвөн өнгө” фото зургийн уралдаануудыг зохион байгуулах юм.

Баяндун сумын нутагт жоншны ордод бичил уурхай эрхлэх гэрээг Баяндун сумын Засаг даргатай байгуулсан “Түшиг баян түмэн” ЗГБХН-ийн 2019 оны ашиглалтын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулахаар ирүүлсэн бичиг баримтыг хянан үзсэн. Бичил уурхайн зориулалтаар олгож, гэрээ байгуулсан газар нь аймгийн ИТХ-ын 2014 оны 08 дугаар тогтоолоор 2014-2019 он хүртэлх хугацаагаар орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан “Баяндун уул” нэртэй газрын хамгаалалтын бүстэй давхцалтай байна. “Баяндун уул” нэртэй орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг аймгийн ИТХ-ын 2018 оны 13 дугаар тогтоолоор 25 жилийн хугацаагаар хамгаалалтанд авч, Улсын тусгай хамгаалалтанд авахаар Монгол улсын Засгийн газраас дэмжигдсэн газар нутгийн жагсаалтанд багтсан газар нутаг юм. Тиймээс “Түшиг баян түмэн” ЗГБХН-ийн бичил уурхай эрхлэх үйл ажилагааг дэмжих боломжгүй гэдгийг Баяндун сумын ИТХ, Засаг дарга, нөхөрлөлд албан бичгээр тус тус хүргүүлсэн.

“Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхэд бүх нийтийн оролцоо” сэдэвт хэлэлцүүлгийг 3 сарын 22-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хурлын танхимд зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт аймгийн удирдлагууд, Бүсийн төв, Дорнод аймгийн Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Буйр нуур-Мэнэнгийн сав газрын захиргаа, сумын Засаг дарга нар оролцож ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумдын зохион байгуулж байгаа ажилтай танилцаж цаашид хэрхэг ажиллах талаар чиглэл өгч ажилласан. Энэхүү хэлэлцүүлэгт Бүсийн төв, Дорнод аймгийн Онцгой байдлын газраас “Дорнод аймгийн гал түймрийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” сэдэвт илтгэл танилцуулж, сумын Засаг дарга нар ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутагт хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар санал бодлоо солилцон, аймгийн Засаг дарга холбогдох үүрэг чиглэлүүдийг өглөө.

Аймгийн Засаг даргын А/104 дүгээр захирамжийн хүрээнд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын постыг ажиллуулж тээврийн хэрэгслийн яндангийн оч баригч, яндан доор хуримтлагдсан өвсийг унагаах сэтгүүр төмөр, галын хор зэргийг шалгаж хэвлэмэл анхааруулга санамжийн хуудсыг тараах ажлыг 2019 оны 3 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн зохион байгуулж байна. Байгаль орчны газар ой, хээрийн түймрийн хариуцлагатай жижүүрийг “Ойн тухай” хуульд заасан түймрийн аюултай улирал болох 3-р сарын 20-ны өдрөөс эхлэн гаргаж өглөөний 8 цагаас оройн 21 цаг хүртэл байгууллага дээрээ ажиллуулж, БОАЖЯ-ны хариуцлагатай жижүүртэй өдөр бүр 3 удаа холбогдож түймрийн мэдээ болон салхины хурд, хур тундасны мэдээ өгч байна. Ой, хээрийг түймрийн аюултай улиралд түймрээс урьдчилан сэргийлэх анхааруулгыг орон нутгийн телевиз “DTV”, “Мижиг”, “Шинэ суваг”, “PBS”, “TV-6” зэрэг телевизүүдээр өдөрт 8 удаагийн давтамжтай явуулж эхлээд байна.

Хишиг дэлгүүр, ХААН банк, EF сүлжээ дэлгүүр, EURO 10000, Хэрлэн номин худалдааны төв, Шүр зах, Хөгжмийн дэлгүүр, Олихон худалдааны төв, шатхуун түгээх станцууд гэх мэт хүн ам ихээр үйлчлүүлдэг байгууллагуудад ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх анхааруулга санамжийн хуудас /плакат/ 20 ширхэгийг байршууллаа.

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 189 дүгээр тогтоолоор 2019 оны 3-р сарын 1-нээс бүх төрлийн 0.035 мм болон түүнээс нимгэн нэг удаагийн нийлэг хальсан уутыг худалдаа, үйлчилгээнд сав баглаа боодлын зориулалтаар үйлдвэрлэх, импортлохийг хориглосон тогтоол хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь WWF-Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газарт “ДААВУУН УУТТАЙ ДОРНОД” аяныг зохион байгуулах талаар төсөл бичиж 3.5 сая төгрөгийн санхүүжилт авч байгаль хамгаалах нөхөн сэргээх зардалаас 3.0 сая төгрөг

нийт 6.5 сая төгрөгийг шийдвэрлүүлээ. Батлагдсан төлөвлөгөөний дагуу уг аянд Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргаа, Улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын “Дорнод” хамгаалалтын захиргаатай хамтран “ДААВУУН УУТТАЙ ДОРНОД” аяныг аймгийн хэмжээнд өрнүүлэн дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

Үүнд:

1.Оёдолчдын холбоотой хамтран ажиллаж сургалтаар мэдлэг олгов.

Дорнод аймгийн Оёдолчдын холбоо ТББ-ын гишүүн 35 гаруй оёдолчидтой уулзалт, сургалт зохион байгууллаа. Уг сургалтаар Монгол улсын Засгийн газрын 2018 оны 189 дүгээр тогтоолыг танилцуулж будаа, элсэн чихэр, хүнсний ногоо, жижиглэнгээр авч буй бүтээгдэхүүн хийх 10-ын нийлэг хальсан уутыг орлох бүтээгдэхүүний шийдлүүдийн талаар танилцуулгыг бэлтгэж танилцууллаа. Мөн аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулах Уулзалт хэлэлцүүлгийн үеэр худалдаа эрхлэгчидэд сурталчилан таниулах зорилгоор Хэрлэн сумын иргэд ААН,ТББ –ууд өөрсдийн оёсон даавуун уут, цаасан уутны үзэсгэлэн гаргаж танилцуулсан

2. “Иргэнд үйлчлэх төрийн үйлчилгээ” гялгар уутны стандарт, төрийн хяналт шалгалт хийх талаар нэгдсэн ойлголтод өглөө

Аймгийн Засаг даргын орлогч Ш.Ёл, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Хэрлэн сумын Засаг даргын тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Буйр нуур- Мэнэнгийн талын сав газрын захиргаа, Улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын Дорнод хамгаалалтын захиргаа, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, аймгийн Стандарчилал хэмжил зүйн хэлтэс хамтран “Талуудын уулзалт хэлэлцүүлэг” арга хэмжээг 3 сарын 05-ны өдөр аймгийн Засаг даргын тамгын газрын хурлын танхимд зохион байгууллаа. Уг уулзалт хэлэлцүүлэгт Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй томоохон бизнес эрхлэгч, хүнсний дэлгүүрүүд, супермаркетуудын дарга эрхлэгчид, Шүр зах, худалдааны төвүүдийн 80 гаруй төлөөлөл оролцож тогтоолын хэрэгжилтийг хангахад тулгарч буй асуудлуудын талаар санал хүсэлтээ хэлж, тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудлуудаар холбогдох төрийн байгууллагуудаас тодруулга мэдээллүүдийг авлаа.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуйн байцаагч Ганчимэг худалдаалах, импортлох, хэрэглэхийг хуулиар хориглосон уутны талаар мэдээлэл өглөө. Хувийн хэвшлийн бизнесийг дэмжих чиглэлээр “Холбох гүүр” арга хэмжээг 2018 оны 3 сард зохион байгууллаа. Дорнод аймагт нийлэг хальсан уутны оронд хэрэглэх даавуун уут, эрүүл мэндэд хоргүй эко цаасан уутыг үйлдвэрлэгч БОГЦХОН бренд, Eco mp, дахин боловсруулсан цаас үйлдвэрлэгч “Сайн цаас” ХХК, Ретраск ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэсэн байгаль ээлтэй эко даавуун уут сав, баглаа боодлын дээжээс танилцуулан тэдгээрийн холбох гүүр болсон юм.

Аймгийн Оёдолчдын холбоо ТББ-ын 15 оёдолчин, ANTS бүлэг, Солонго баг, Улсын тэргүүний 5 дугаар сургуулийн хүмүүнлэгийн бүлэг,Бадмаараг бөс бараа, оёдолын цех, Баян-Уул сумын Ахмадын зөвлөл, “Бид Дорнодын залуус” бүлэгээс даавуун уут оёж зах зээлд худалдаж буй иргэд, ТББ, бүлэг, хоршоодын төлөөлөл оролцон өөрсдийн оёсон даавуун уутнуудыг танилцуулж дэлгүүрүүдээс авлаа.

Улсын тэргүүний 5 дугаар сургуулийн Хөдөлмөрийн багштай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн 9-10 дугаар ангийн сургачдад Даавуун уут хийх талаар сургалт зохион байгууллаа. Уг сургалтыг 9-10 дугаар ангийн 62 эмэгтэй сурагч оролцож даавуун уут, аяганы уут, пүүз, кет хийх даавуун цүнхийг оёж сурсан. Хүмүүнлэгийн клубын охидод даавуун уут хийх материалын зардалд 80000 төгрөгийн дэмжлэг үзүүлэн Даавуун уут оёх хичээл бэлтгэн орон нутгийн D1 телевизтэй хамтран нэвтрүүлэг бэлтгэн гаргаад байна. Ерөнхий боловсролын 1,2,5,8 дугаар сургуулиудын сурагчдад “Нийлэг хальсан уутнаас татгалзъя” сургалт зохион байгууллаа. Сурагчид үдийн завсарлагаанаар цайны газруудаар үйлчлүүлэхдээ ширхэгийн хоолыг нэг удаагийн нийлэг хальсан уутанд халуунаар нь хийж авч идэх нь элбэг байдаг бөгөөд эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж буй талаар уг сургалтын үеэр сурагчид санал хэлж байлаа. 4 сургуулийн 5-р ангийн 300 орчим сурагчид сургалт зохион байгууллаа. “Нийлэг хальсан уутнаас татгалзъя” видео бичлэгийн улсын уралдаанд оролцохыг сурагчдад уриалан ажиллаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цэнгэг ус байгаль хамгаалах төвөөс зохион байгуулсан "Нийлэг хальсан уутнаас татгалзъя" видео бичлэгийн улсын уралдаанд Ерөнхий боловсролын сургуулиудыг оролцохыг уриалан ажилласан. Энэхүү уралдаанд 3 сургуулийн бүтээл оролцсон бөгөөд 8 дугаар сургуулийн Шүхэрцэнд багштай Экоклубын видео бичлэг 3 дугаар байранд шалгараад байна. Энэхүү видео бичлэгийн уралдаанд шалгарсан 7 сурагч, багштайгаа хамт 4 сарын 06-11-ны өдрүүдэд Олон улсын "Найрамдал" зусланд амрахаар болоод байна.

"Даавуун ууттай Дорнод -2019 аян"-ыг төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын дунд зарлаад байна. аймгийн Засаг даргын тамгын газрын хамт олон уг аяныг дэмжин "Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх" зорилтот жилийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас зохион байгуулагддаг ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэн Э.Цогбаярын үйл ажиллагааг дэмжин аймгийн Засаг даргын Тамгын газрын хамт олон 77 ширхэг даавуун уутыг захиалан оёулж "ДААВУУН УУТТАЙ ДОРНОД"аянд нэгдлээ. Энэхүү аяныг аймгийн аж ахуйн нэгж байгууллагуудын дунд өрнүүлээд байна.

Хууль, тогтоолын хэрэгжилтийн явц сумдад:

Хэрлэн сумын хэмжээнд: Дорнод аймгийн 13 сумын Байгаль орчны тасагт 2 төрлийн плакатыг хэвлэн тус бүрт 200 ш хүргүүлээд байна. Аймгийн төв Хэрлэн сумын 10 багт 415 ш Супермаркетууд, Шүр зах, худалдааны төв, хүнсний 8 нэрийн дэлгүүр, цайны газар, үйл ажиллагаа явуулдаг уг газруудад 2 төрлийн тараах материалуудыг хэвлэн тарааж наах ажлыг 2 сарын 25-с 3 сарын 25-ны хүртэл хугацаанд хэрэгжүүлэн Хэрлэн сумын байгаль хамгаалагч Т.Болдбаатартай хамтран нийт 400 аж ахуйн нэгжийг хамруулан худалдаа эрхлэгчидэд хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар сурталчилгааны ажлыг өрнүүлээд байна.

Дашбалбар сумын хэмжээнд: Байгаль орчны байцаагч 2-р сарын 27-ны өдөр сумын 15 дэлгүүрт зөвлөмж хүргүүлэн ажилласан. Мөн 2-р сарын 21, 22, 24, 25, 27 өдрүүдэд багийн хурал дээр Засгийн газрын 189-р тогтоолыг танилцуулж даавуун уутаа хэрэглэж хэвшихийг уриалсан. Тараах материалыг нийт 217 иргэнд өгөв.

Засгийн газрын 189-р тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс "ЭКО ТОР-БИДНИЙ ХЭРЭГЛЭЭ" уралдааныг удирдамж батлуулан ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн /9-12 дугаар анги / хүүхдүүдэд даавуун уут оёх уралдаан зарласан. Энэ уралдаанд 21 хүүхэд оролцсон бөгөөд:

Тэргүүн байранд 11а ангийн Б.Хулан

Дэд байранд 11а ангийн Б.Номинцэцэг

Гутгаар байранд 9а ангийн Ө.Жавхлан

Тусгай байранд 10а ангийн Минжинсор

Тусгай байранд 10а ангийн С.Сайнзаяа тус тус байр эзэлсэн. Мөн 3-р сарын 15, 17-ны өдрүүдэд ГЯЛГАР УУТ-ыг 03 сарын 01-нээс хэрэглээнээс халсан 189-р тогтоолын танилцуулга тараах материалыг дэлгүүр болон албан байгууллага, аж ахуй нэгжүүдэд тараасан.

2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 17 цагаас сумын Соёлын төвд "Иргэдтэй уулзах өдөр" үйл ажиллагааг Сэвсүүл-Жараахай баг, Хүн эмнэлэгтэй хамтран зохион явууллаа. Энэхүү арга хэмжээнд 79 иргэн хамрагдав. Байгаль орчны тасгаас Байгаль орчны хяналтын улсын байцаагч Д.Билгүүн хог хаягдал болон засгийн газрын 189-р тогтоолыг танилцуулж мэдээлэл өгсөн.

Матад сумын хэмжээнд: Монгол Улсын Засгийн газрын 189 дүгээр тогтоолын дагуу бүх төрлийн 0,035мм-ээс түүнээс нимгэн, 1 удаагийн нийлэг хальсан уутны худалдаа, үйлчилгээний сав, баглаа боодлын зориулалтаар импортлох, үйлдвэрт хэрэглэхийг 2019 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хориглосонтой холбогдуулаад "Гялгар уутгүй Матад" гэсэн уриалга гаргаж сумын дэлгүүрээр тарааж сумын мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн. Тус тогтоол гарсантай холбоотойгоор олон дахин ашиглах

боломжтой орон нутгийн даавуу уут үйлдвэрлэгчдийг сурталчилах зорилгоор 2019 оны 4-р сарын 10-ны өдөр үзэсгэлэн худалдаа зохион явуулах гэж байна.

Баяндун сумын хэмжээнд: Сумын хэмжээнд бүх төрлийн 0.035 мм болон түүнээс нимгэн , нэг удаагийн уутыг худалдаа үйлчилгээнд сав, баглаа боодлын зориулалтаар импортлох, үйлдвэрлэх, хэрэглэхийг хориглож давхардсан тоогоор 300 орчим иргэдэд тогтоолийг танилцуулж ажилласан. Мөн 5 байгууллага 12 ААНэгж байгууллагын самбаруудад байршуулж тогтоолийг танилцуулж ажилласан.

Хөлөнбуйр сумын хэмжээнд: Монгол улсын Засгийн газрын 2018 оны 189 дүгээр тогтоолоор "Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай" тогтоол гарсантай холбогдуулан "Эко орчин, даавуун уут-Амьдралын хэрэглээ" уриан дор сумын Засаг даргаар баталсан удирдамжийн дагуу дараах ажлуудыг зохион байгууллаа. Удирдамжинд тусгасанаар "Нийлэг хальсан уутны хор нөлөө, даавуун уутны хэрэглээ" сэдэвт сургалтыг зохион байгуулсан бөгөөд сургалтад ЕБС-ын ахлах ангийн сурагчид, сумын өндөр настан, төсөвт байгууллагын албан хаагчид хамрагдсан. Мөн "Эко орчин, даавуун уут-Амьдралын хэрэглээ" уриан дор "Даавуун уут" урлах, мөн олон нийтийг хамарсан гар бөмбөгийн тэмцээн зохион байгууллаа.

Гар бөмбөгийн тэмцээнд Дорнод аймгийн Шунхлай ШТС-ын хамт олон, мөн Хөвчийн талын баялаг ХХК, Баян-Уул баг зэрэг нийт 8 баг хурд хүч авхаалж самбаагаа сорьжоролцсоноос А.Ариунболд ахлагчтай "Хөвчийн талын баялаг" ХХК тэргүүн байр, Ч.Батдорж ахлагчтай "Батхаан" баг 2 дугаар байр, Б.Буяннэмэх ахлагчтай хүүхдийн цэцэрлэгийн баг 3 дугаар байр тус тус эзэлсэн. Тэмцээнд оролцсон баг хамт олон даавуун уутыг өдөр тутмын амьдралдаа хэрэглэн хэвшиж байгаль орчин болон өөрийн эрүүл мэндээ хамгаалцгаая, нийлэг хальсан уутны хор нөлөө, нийлэг хальсан уутнаас татгалзъя, Нийлэг хальсан уут биш даавуун уутыг хэрэглэж хэвшигчээ зэрэг уриалга гаргасан. "Даавуун уут урлах" уралдаанд 10 гаруй өндөр настан, иргэд оролцсоноос ЕБС-ын дотуур байрны үйлчлэгч Ү.Отгонцэцэг 1 дүгээр байр, тус сумын "Батхаан" багийн өндөр настан Марташгүй 2 дугаар байр эзэлсэн. Мөн ЕБС-ын А.Цэцэгмаа багштай 4 дүгээр ангийн эцэг эхчүүд тус уралдаанд идэвх санаачлагатай оролцож хүүхэд бүрийн өдөр тутмын хэрэглээндээ хэрэглэх биеийн тамирын хувцас, хэрэглэлээ хийх уутыг оёж урласан.

Цагаан-Овоо сум: Уг тогтоол гарсантай холбогдуулан сумын төсөвт 5 байгууллагын ажилчид албан хаагчдад уг тогтоолын талаарх мэдээллийг хүргэж хэвлэгдсэн гарын авлага тарааж гэр орондоо хэвшил болгохийг уриалан ажилласан. Мөн суманд хувиараа оёдол оёдог иргэдийг даавуун уут оёж хүнсний дэлгүүрүүдэд тавьж борлуулах талаар ярилцан ажиллаж байна. Мөн даавуун уутны үнийг 3000 төгрөг байхаар оёдолчидтой тохиролцсон. Хүнсний дэлгүүр ажиллуулж байгаа аж ахуй нэгжүүдийн эздүүдтэй уулзаж Засгийн газрын 2018 оны 189 дүгээр тогтоолоор 2019 оны 03 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэх "Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох" тухай тогтоол танилцуулж цаашид хэрэгжүүлж хамтарч ажиллахыг уриалсан. Сумын ээлжит багийн хурлууд 2019 оны 01 сарын 21-25 ний өдрүүдэд сумын төвд болж өнгөрлөө. Багийн хурлаар БОТХТасгийн хүрээнд мэдээллээ өгч, 189 дүгээр тогтоолын талаарх мэдээллийг иргэдэд өгч ажиллалаа. Багийн ээлжит хуралд давхардсан тоогоор 250 орчим иргэн хамрагдсан байгаа. Сумын ЗДТГазрын самбар аж ахуй нэгжүүдийн мэдээллийн самбаруудад гарын авлага боршурыг нааж ажилласан.

Олон нийтийн хэргсэл цахим орчинд иргэдийг мэдээллээр хангах, сургалт, сурталчилгаа хийсэн ажлууд:

Орон нутгийн D1 телевизтэй хамтран 2 тв шторк, 1 нэвтрүүлэг бэлтгэн орон нутгийн телевизүүдээр цацалт хийлгэсэн. "Шинэ суваг", "PBS", "TV6", "D1" Аяны талаар давхардсан тоогоор 13 удаа мэдээ, мэдээлэлийг телевизүүдээр видео сургалт хийж нийт 45000 иргэнд сурталчилж ажилласан. Мөн Дорнод аймаг Байгаль орчин facebook хаягаар сурталчилан ажиллаж байна.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:

Газрын харилцааны асуудал:

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас зохион байгуулсан "Удирдах ажилтны зөвлөгөөнд тус газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга О.Алтантуяа оролцож сумдын Мал үржлийн тасгийн

мэргэжилтнүүдийн Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах ажилд оролцох оролцоо, цаашид анхаарах асуудлын талаар мэдээлэл өгч харилцан санал солилцов. Тус газар нь 2019 онд Баяндун, Чулуунхороот, Булган, Чойбалсан сумдын Засаг дарга нарт мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч хамтран ажиллахаар болсон. Энэхүү ажлын хүрээнд 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдөр Баяндун суманд ажиллаж сумын Засаг дарга, Газрын даамал нарт багийн хилийн заагийн талаар, багийн иргэдийн Нийтийн Хуралд оролцон иргэдэд газрын кадастр, газар эзэмшил, ашиглалт, өмчлөлийн талаарх мэдээллийг өгч ажиллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл /бүс/, суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай" 182 дугаар тогтоолд нийцүүлэн Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах талаар сумдын Засаг дарга нарт 2019 оны 129 дүгээр албан бичгээр хүргүүлэв.

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас 2015-2018 онуудад сумдын газрын даамлуудын үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг 2019 онд хийхээр төлөвлөгдсөний дагуу газар зохион байгуулалтын төлөвлөгөө, сумын Засаг даргын захирамж, газар эзэмшигч, ашиглагчдын судалгаа, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын баримтууд, газрын төлбөр ногдуулалт, газрын нэгдмэл сангийн тайланг 2015-2018 он тус бүрээр, аймгийн Засаг даргын Тамгын газрын 2 дугаар байр Төрийн аудитын газарт 2019 оны 04 дүгээр сарын 01-ний дотор хүргүүлж ажиллах талаар сумдын Засаг дарга нарт 2019 оны 152 дугаар албан бичгээр хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/30 тушаалаар газраас авах үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тайлангийн ТТ-23/1/ маягт, газрын төлбөрийн тайлангийн ТТ-20 маягт шинэчлэгдсэн. Тиймээс эдгээр маягтын дагуу газрын төлбөрийн цахим тайлан илгээгдэх болсон тул 2019 оны 04 дүгээр сарын 10-ны дотор ирүүлэх талаар сумдын Засаг дарга нарт 2019 оны 188 дугаар албан бичгийг хүргүүлэв. Газрын төлбөрт 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 414 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 89.675,2 мянган төгрөг төсөвт төвлөрсөн байна. Гүйцэтгэл 87 хувьтай байна.

Газрын кадастрын мэдээллийн санд 35 иргэн аж ахуйн нэгжийн кадастрын зургийг мэдээллийн санд оруулж өөрчлөлт хийсэн. Дундын мэдээллийн сангаар дамжуулж 10 иргэн аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг илгээгээд байна. Аймгийн хэмжээнд одоо мөрдөгдөж буй хилийн цэсийн шугамын гадна талд болон дамнан олгосон зөрчилтэй нэгж талбарын судалгааг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлсэн.

Барилга, хот байгуулалтын ажлын чиглэлээр:

Стандарт хэмжил зүйн газраас 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Дорнод аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дэргэдэх Барилгын материалын сорилт, шинжилгээний лабораторит MNS ISO/IEC 17025:2018 стандартын дагуу итгэмжлэлийн үнэлгээ хийж 3 үл тохирол илэрснийг арилгаж, Барилгын материалын лабораторит дээж хадгалах өрөө, дээж хураах тавиур хийж, Мэргэжлийн хяналтын газар болон Онцгой байдлын газраар ажлын байрны дүгнэлт гаргуулан 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 182 тоот албан бичгээр хариу хүргүүлэн ажиллалаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хэрлэн сумын 8 дугаар багт "Стандарт рэзидэнс констракшн" ХХК хийж гүйцэтгэсэн 2 дугаар сургуулийн спорт заалны барилга угсралтын ажлыг аймгийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/92 дугаар захирамжийн дагуу улсын комисс ашиглалтад хүлээн авч ажиллалаа. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Канадын улсын Мерит төсөлтэй хамтран 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан илтгэгч Рон Шэрлэтийн багийн ажиллагаа, харилцаа холбооны 8 цагийн сургалт, хөтөлбөрт хамрагдан сертификат авсан. Барилга хот байгуулалтын яамнаас Улаанбаатар хотод 2019 оны 04 дүгээр сарын 24-27-ны өдрүүдэд зохион байгуулсан "Барилгын салбарын удирдах ажилтан"-ы зөвлөгөөнд 8 хүний бүрэлдэхүүнтэй оролцон төрийн бодлого шийдвэртэй танилцан, харилцан туршлага солилцож ажиллалаа.